



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 04 • № 44

Б.БАЯРДАВАА:

БИЗНЕСИЙГ
ИДЭВХЖЛИЙН
УЛИРАЛД НЬ
ДЭМЖИХ ЗОРИЛГООР
БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙГ ЦАГ
АЛДАЛГҮЙ ГАРГАСАН

“КОВИД-19” ЦАР
ТАХЛЫН ТАРХАЛТЫН
СЦЕНАРИО
ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРААНГУЙ



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС
ШАР БОЛОР



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

ДУГААР: 2020 | 02
ОГНОО: 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар 1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэх, 2) эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2020 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 6.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.9 хувь байна. Эдийн засгийн өсөлт энэ онд саарч, эрэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэхээргүй байна. Импортын хүнсний зарим бүтээгдэхүүний хангалт доголдохгүй тохиолдолд нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын хэлбэлзэл үүсэхгүйн дээр дэлхийн зах зээл дээр газрын тосны үнийг даган дотоодын шатахууны үнэ буурч байна.

Шинэ корона вирусийн дэгдэлт үргэлжилж, эдийн засгийн гадаад, дотоод нөхцлийг богино хугацаанд өөрчилж, тодорхой бус байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн идэвхжлийг бууруулах, бизнесийн үйл ажиллагааг хумих, улмаар зээлдэгчдийн эргэн төлөлт хүндрэх зэрэг нөлөөг үзүүлж байна. Иймээс вирусээс үүдэлтэй эдгээр хүндрэлийг бууруулах, цаашид эдийн засгийн идэвхжлийг дэмжихэд чиглэсэн мөнгөний болон макро зохистой бодлогын шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулахын зэрэгцээ хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийг 12 сар хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж зээлийн сарын эргэн төлөлтийн хэмжээг бууруулах бодлогын багц шийдвэрийг гаргаж байна.

Мөнгөний бодлогын хорооны энэ удаагийн шийдвэр нь инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг болно.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



05

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ:

ХАЛДВАРТ
ӨВЧИН
СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВД
ЭМНЭЛГИЙН
ЯАРАЛТАЙ
ТУСЛАМЖИЙН
АВТО МАШИНЫГ
ШИЛЖҮҮЛЛЭЭ



06

ЯРИЛЦЛАГА:

Б.БАЯРДАВАА:

БИЗНЕСИЙГ
ИДЭВХЖЛИЙН
УЛИРАЛД
НЬ ДЭМЖИХ
ЗОРИЛГООР
БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙГ
ЦАГ АЛДАЛГҮЙ
ГАРГАСАН



16

**МОНГОЛ БАНКНЫ
МЭДЭЭЛЭЛ**

2020 ОНЫ
ДӨРӨВДҮГЭЭР
САРД 1.4 ТОНН
ҮНЭТ МЕТАЛЛ
ХУДАЛДАН АВЛАА



15

АСУУЛТ ХАРИУЛТ

ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛИЙН
ХУГАЦААГ
СУНГАХТАЙ
ХОЛБООТОЙ
ТҮГЭЭМЭЛАСУУЛТ,
ХАРИУЛТУУД



18

НИЙТЛЭЛ

МОНГОЛ УЛС
ДАХЬ
ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙН
ХЭРЭГЖИЛТ



23

БАНКИР:

Л.БОЛОРМАА:

ХӨГЖЛИЙН
БОДЛОГОО
ДОР ХАЯЖ 10 ЖИЛ
ТОГТВОРТОЙГООР
ХЭРЭГЖҮҮЛМЭЭР
БАЙНА



20

**ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ**

ОУВС,
ДЭЛХИЙН
БАНКНЫ 2020
ОНЫ ХАВРЫН
ЧУУЛГА
УУЛЗАЛТ



32

**САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ:**

ДААТГАЛЫН АЧ
ХОЛБОГДОЛ

2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2020.04.03

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЦАЙ ВЭНЬРУЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Уулзалтын эхэнд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Монгол Улс болон БНХАУ нь эдийн засгийн нягт хамтын ажиллагаатай болохыг онцлоод, Монгол Улсын хувьд нийт экспортынхоо 90 гаруй хувь, импортын 40 гаруй хувийг БНХАУ-тай хийдэг гэв. Мөн 2011 оноос эхлэлтэй БНХАУ-ын Ардын банк болон Монголбанк хоорондын төгрөг-юанийн своп хэлцлийн хугацааг 2020 оны 7 дугаар сард сунгах талаар яриа хэлэлцээр хийж буй талаар мэдээлэл өгөв. Түүнчлэн Монгол Улсын эдийн засаг 2016 оны төгсгөлд дефолтын эрсдэлд орж хүндэрсэн байсан ч 2017 онд ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сүүлийн 3 жилд эдийн засгийн өсөлт тогтворжиж, инфляц Монголбанкны зорилтот түвшинд нийцтэй байхын сацуу ГВАН нэмэгдэж, ханш тогтвортой байгааг дурдав.

2020.04.06

"ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ МЭДЭЭГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭДЭГ БОЛЛОО



COVID-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээг www.mongolbank.mn цахим хуудсанд тогтмол мэдээлдэг боллоо.

2020.04.22

2020 ОНЫ 3 БОЛОН 4 ДҮГЭЭР САРЫН ИНФЛЯЦЫН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛЛАА



Монголбанкнаас инфляцын тайланг улирал бүр боловсруулдаг бөгөөд ээлжит бус мөнгөний бодлогын шийдвэрүүдтэй нийцүүлэн 4 дүгээр сарын дугаарыг нэмэлтээр танилцуулж байна. Инфляцын тайлангаас Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 3 дугаар сарын болон 4 дүгээр сарын хурлуудад ашигласан суурь тооцооллууд, хувьсан өөрчлөгдөж буй гадаад орчны нөхцөл байдал, түүнээс шалтгаалан дотоод эдийн засгийн төлөвт гарсан өөрчлөлтүүдийг харьцуулан харах боломжтой. Инфляцын тайлан нь Төв банкны олон нийттэй харилцах харилцааны гол арга хэрэгслүүдийн нэг юм. Тус инфляцын тайланг Монголбанкны веб хуудасны "Мөнгөний бодлого цэс"-нээс татаж авч, унших боломжтой.

2020.04.22

САНХҮҮГИЙН ЛУЙВРААС СЭРГИЙЛЭХИЙГ УРИАЛСАН "НЯГТЛАХ ТУСАМ АЮУЛГҮЙ" АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Монголбанкнаас Цагдаагийн ерөнхий газар, арилжааны банкнуудтай хамтран хэрэгжүүлсэн "Ятгах тусам нягтал" аяны үргэлжлэл болгон "Нягтлах тусам аюулгүй" аяныг 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 20-ны өдрийг дуустал зохион байгуулахаар боллоо. Энэ удаагийн аяныг хэрэгжүүлэхэд Монголбанк, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах алба, Хаан банк зэрэг байгууллагууд зохион байгуулж, бусад холбогдох байгууллагууд хамтран оролцож байна. Монголбанк нь энэхүү аянд "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр" -ийн хүрээнд оролцож байгаа бөгөөд санхүүгийн гэмт хэрэгт өртөхөөс сэргийлсэн мэдлэг мэдээллийг түгээх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гаралтыг багасгах зорилготой юм.

2020.04.23

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВД ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН АВТО МАШИНЫГ ШИЛЖҮҮЛЛЭЭ



Дэлхий даяар тархсан Covid-19 вирусийн цар тахлын эрсдэлийн үед Монголбанкны зүгээс татан буугдсан банкны өр авлага барагдуулах ажиллагааны хүрээнд хүлээж авсан эмнэлгийн яаралтай тусламжийн автомашиныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (ХӨСҮТ)-д шилжүүллээ. Тус автомашиныг шилжүүлэн өгөх үйл ажиллагаанд ХӨСҮТ-ийн дарга Д.Нямхүү, ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян нар албаны хүмүүсийн хамт оролцов. Энэ үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн эмнэлгийн яаралтай тусламжийн авто машины түлхүүрийг гардуулан өглөө.

2020.04.29

АНУ-ЫН ЭЛЧИН САЙД МАЙКЛ С. КЛЕЧЕСКИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн АНУ-ын Элчин сайд Майкл С. Клеческийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Дэлхий даяар тархсан шинэ коронавирусын үеийн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож, энэ үед Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар танилцууллаа. Мөн үеэр Монгол Улс Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарах зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулсан бөгөөд энэ хүрээнд ахиц дэвшил гарч байгааг ноён элчин сайд Майкл С. Клечески сайшаалаа. АНУ-аас тус хэрэгжилтийг ханган ажиллаж буй Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дотоод үйл ажиллагаанд олон улсад өргөн хэрэглэгддэг мэргэжлийн программыг худалдаж авах, суурилуулахад шаардагдах санхүүжилт болон зохион байгуулалтын ажлуудад туслалцаа үзүүлэх юм.



Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.БАЯРДАВААТАЙ ярилцлаа.

Б.БАЯРДАВАА:

БИЗНЕСИЙГ ИДЭВХЖЛИЙН УЛИРАЛД НЬ ДЭМЖИХ ЗОРИЛГООР БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ ГАРГАСАН

Мөнгөний бодлогын хороо хуралдаж, бодлогын хүүг дахин буурууллаа. Энэхүү шийдвэрийг гаргах болсон гол үндэслэл юу байв гэдгээс ярилцлагаа эхэлье.

Гуравдугаар сарын 11-нд мөнгөний бодлогын хороо хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болгосон. Үүнээс сарын дараа буюу дөрөвдүгээр сарын 13-нд Мөнгөний бодлогын хороо дахин хуралдаж, бодлогын хүүг 10 хувиас 9 хувь болгож буурууллаа. Үүний хамгийн гол шалтгаан нь гадаад эдийн засгийн

орчин, түүнээс улбаатайгаар дотоод эдийн засаг агших эрсдэл үүссэнтэй холбоотой. Хоёрдугаарт, энэ нь манай эдийн засгийн гол улиралтай давхцаж байгаа учраас бизнесийн идэвхжлийг сааруулахгүйн тулд бодлогын шийдвэрийг ойрхон хугацаанд дараалан гаргалаа.

Түүнчлэн хүндрэлд орсон хэрэглээний зээлийн хугацааг 12 сараар сунгах бололцоог хангасан шийдвэр гаргасан. Энэ өрхийн хувьд зээлийн эргэн төлөлттэй холбоотой санхүүгийн дарамтыг бууруулах, улмаар хэрэглээний сөрөг шокыг

зөөлрүүлэх байдлаар эдийн засгийн эрэлтийг дэмжих зорилготой.

■ Гадаад эдийн засгийн нөхцөл байдал ямар байна вэ. “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор дэлхийн эдийн засаг хямарч, буурч байна шүү дээ. Энэ нөхцөл байдлыг төв банк хэрхэн харж, дүгнэж байна вэ?

Монголбанкны зүгээс 2018 оны сүүлээс эхлээд олон нийт, бизнес эрхлэгчдэд гадаад эдийн засгийн орчин таагүй байх нь гэдгийг анхааруулж байсан. Гэхдээ шалтгаан нь бидний бодсоноос өөр байлаа. Ковид үүсээгүй байсан ч ер нь гадаад орчин муудахаар байсан гэсэн үг. Гэхдээ ийм гүнзгий хүнд биш байх байсан.

КОВИД-19 ВИРУСЭЭС УЛБААЛСАН ЭНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖИЛ, ХУДАЛДАА, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ДОРГИО ҮҮСГЭЖ МАШ ГҮНЗГИЙ УНАЛТ, ТОДОРХОЙ БУС БАЙДАЛД ХҮРГЭЛЭЭ.

ОУВС-ийн дэлхийн эдийн засгийн хандлагын тайлангаас харахад 3 сарын өмнө +3 хувийн өсөлттэй байхаар хүлээгдэж байсан дэлхийн эдийн засгийн өсөлт –3 хувь болж, 6 хувийн өөрчлөлт бий болж байна. Энэтхэг, Хятадыг эс тооцвол дэлхийн эдийн засгийн 2/3-ыг бүрдүүлдэг 10 том эдийн засаг 2020 онд 5-9 хүртэлх хувиар агшихаар байна.

Оны эхнээс хөрөнгийн зах зээл дээр үнэ 20-30 хувиар, таваарын үнэ дунджаар 20 гаруй хувиар, үүний дотор металлуудын үнэ 15 орчим хувиар унаж, эрчимтэй хөгжиж буй орнуудаас валют их хэмжээгээр америк руу шилжиж, тэдгээрийн үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш дунджаар 10 гаруй хувиар ам.долларын эсрэг суларч, эрсэдлийн үнэ 3-4 дахин нэмэгдсэн, хөгжиж буй улс орнуудын Засгийн газрын зээлжих хүү 2 дахин өссөн зэрэг нөхцөл байдал үүсээд байна.

■ Энэ хямралаас гарахад хэдий хугацаан шаардлагатай вэ?

Одоогийн нөхцөл байдлаас харахад сайнаар бодоход энэ оны 2 дугаар хагаст сэргэлт эхлэх таамагтай байна. Гэхдээ энэ хямрал нь өмнөх хямралуудаас шалтгаан, үр дагавар, хямралаас гарах жорын хувьд эрс ялгаатай болохоор тааварлахад маш хэцүү. Эдийн засгийн бус шалтгаанаас хамааралтай. Тэр вирус, түүний тархалт, түүнийг эмчлэх хяналтандаа оруулж чадах эсэхээс сэргэлт хамаарна. Аль ч улс хэчнээн мөнгө нийлүүлээд хөл хорио бүрэн тавигдаагүй бол, эсвэл тавигдсан ч хүмүүсийн айдас болгоомжлол арилаагүй тохиолдолд эдийн засгийн бодлогын үр нөлөө сул байх болно. Тухайлбал, 2008/09 оны хямрал бол санхүүгийн зах зээлээс улбаалан эрэлтийг агшаасан хямрал байсан. Энэ удаагийнх бол өвчний нөхцөл байдлаас үүдэлтэй хөл хорио тогтоож, хүмүүс гэртээ үлдсэнээр эдийн засгийн идэвхжил, үйл ажиллагаа зогсож байна. Ингэснээр эрэлтийг эрс бууруулж, улмаар нийлүүлэлтийн суваг тасарсан. Түүнчлэн, санхүүгийн зах зээл дээр 2008, 2009 оных шиг хүчтэй доргио үүсч, хөрөнгийн үнэ цэнэ унасан.

■ Гуравдугаар сард Монголбанк бодлогын хүүгээ бууруулж, 10 хувь болгосон. Гэтэл ээлжит бус хуралдаанаар дахин 1 нэгж хувиар бууруулсан нь ямар үр дүнг хүргэх гэсэн шийдвэр вэ?

Бодлогын хүүгийн бууралтын үр дүн 14 хоног эсвэл нэг сарын дотор гарахгүй. Яагаад гэвэл бид зах зээлийн харилцаанд амьдарч, бизнес хийж байгаа. Тэгэхээр бизнесийн харилцаанд өөрчлөлт гарч байж, үр дүн нь гарна. Бид яагаад гуравдугаар сараас хойш дахиад нэг сарын дараа бодлогын хүүг бууруулсан бэ гэхээр эдийн засгийн төлөв байдлын муу нөхцөл байдал нь хүлээлтээс давж байна.

Өөрөөр хэлбэл, 2, 3 дугаар сарын төлөвт үндэслэн эдийн засгийн өсөлтийг 2020 онд 4 орчим хувь буюу 2-дугаар улирлаас байдал сайжрахаар хүлээлттэй байсан. Хятадын хувьд таамаглал биелсэн боловч Европ, Америкийн нөхцөл байдал муугаар эргэсэн. Шинэчилсэн нөхцөлөөр бол хоёрдугаар улирлыг дуустал дэлхий нийтэд энэ вирусийн нөхцөл байдал хүнд хэвээр байх нь. Америк, Европ хоёр сайнаар бодоход хоёрдугаар улиралдаа багтаад вирусийн тархалтыг хяналтандаа авснаар

гадаад орчныг даган дотоод орчин сүүлийн хагаст сэргэнэ гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, сэргэлтийг 1 улирлаар хойшлуулснаар эхний хагас бүхэлдээ ЭЗӨ хасах байж, сүүлийн хагаст сайжрах ч эдийн засгийн өсөлтийг 1.8 хувь болгож буурууллаа. Бодлогын хүүнээс гадна

МОНГОЛБАНКНААС ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦ, БАНКНУУДАД ОЛГОЖ БАЙГАА САНХҮҮЖИЛТИЙН ХҮҮ, БАНКНУУДЫН ТӨВ БАНК ДАХЬ ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГ БУУРУУЛАХЫН ЗЭРЭГЦЭЭ ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОН БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ ӨӨРЧЛӨХ БОЛОМЖИЙГ АРИЛЖААНЫ БАНКНУУДАД ОЛГОЖ БАЙНА.

■ Бодлогын хүү буурснаар зээлийн хүү буурах уу?

Бодлогын хүү гэдэг Төв банк болон арилжааны банк хоорондын зээл, хадгаламжийн хүүний суурь хүү юм. Энэ нь цаашаа банк болон ААН, иргэд хоорондын зээл, хадгаламж зэрэг хэлцлийн суурь хүү болдог. Бодлогын хүүг бууруулсны зорилго нь бизнесийн идэвхжлийн хаврын улиралд зээлийг аль болох эдийн засаг руу гаргах зорилготой.

Өөрөөр хэлбэл, банкнуудын нөөц төв банкны үнэт цаасанд байрших таатай боломжийг бууруулж байгаа юм. Банкнууд нөөцийнхөө тодорхой хувийг нь харилцагчийнхаа төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэхийн тулд төв банканд байршуулах ёстой. Энэ нөөцийн дундаж өгөөжийг бодлогын хүү тодорхойлдог. Нөгөө талд нь банк эх үүсвэрээ зээлд гаргах ёстой. Өнөөдрийн байдлаар зээлийн дундаж хүү 17 хувь байна.

Түүнчлэн банкнууд 12-13 хувиар хадгаламж татаад, 9 хувийн хүүтэй Төв банкны үнэт цаасанд байршуулах нь алдагдалтай. Бас бодлогын хүү буурснаар зээл олгоогүй алдагдсан боломжийн өртөг нэмэгдэж байна. Зээл олгохгүй бол 9% дээр нөөцөө байршуулна гэсэн үг. Иймд бодлогын хүү 11%-иас 9% болж буурсан нь банкнуудыг

санхүүгийн механизмаар зээл гаргахыг шахаж байгаа юм. Түүнчлэн бодлогын хүү буурснаар нөөц дутагдах үед Төв банкнаас банкнуудын авдаг санхүүжилтийн хүү дагаж буурдаг. Энэ хүү 13 хувиас 10 хувь болж буураад байна.

■ Бодлогын хүүг бууруулснаар өөр ямар боломжууд бий болох вэ?

Бодлогын хүү буурч зээл олгоогүй алдагдсан боломжийн зардал өсч байгаа нь зээлийн зах зээл дээрх банкнуудын өрсөлдөөнийг ширүүсгэнэ. Энэ өрсөлдөөн нь зээлийн хүү, зээлийн хугацаа, үнэлгээ, барьцаа хөрөнгө, санхүүгийн зөвлөгөө гэх мэт олон янзаар илэрнэ.

Энэ нь зээлдэгчдэд илүү таатай нөхцөлийг бий болгоно. Өнөөгийн орчинд зээлдэгчийн сууриа тэлж чадсан банк түр зуурын шинжтэй энэ хямралт нөхцөл байдал арилах үед илүү хурдан өсөх бололцоог олж авах тул сайн зээлдэгчийн төлөөх банкнуудын өрсөлдөөн ширүүн байх болно. Мэдээж энэ нь тухайн банкны санхүүгийн чадавхаас бас хамаарна. Урт хугацааг харж, харьцангуй тогтвортой байдлыг эрхэмлэдэг банкнуудын давуу тал өдийд илрэх боломжтой.

■ Үүсээд байгаа нөхцөл байдалд Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд аль аль талдаа дэмжлэг болж чадаж байна гэж харж байгаа юу?

Бид нэг талаас банкнуудыг санхүүгийн механизмаар маш хүчтэй шахаж байгаа. Эдийн засгийн хувьд тодорхой бус нөхцөл байдал үүссэн байгаа үед зээл олгохыг шахаж байгаа гэдэг нь тэднийг тодорхой хэмжээнд эрсдэл үүрэхийг шаардаж байна гэсэн үг. Нөгөө талдаа шинэ зээл гаргахдаа банкнууд хөшүүн байж болох талтай тул зээлийг банканд эргүүлэн татагдахаас илүү зээлдэгчийн гар дээр нь үлдээх зорилгоор эргэн төлөлтийг хойшлуулах, хугацааг сунгах зэрэг арга хэмжээг макро зохистой бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байна.

Түүнчлэн банкнууд төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа сайжруулах зорилгоор Төв банкнаас зээл авах нөхцөл үүсвэл энэ хэрэгцээг илүү хямдаар хангах үүднээс санхүүжилтийн хүүгээ 13% байсныг 10% болгож бууруулаад байна. Банканд зээл олгох барьцаа хөрөнгийн жагсаалтыг ч бас нэмэгдүүлсэн.

■ Банкнүүдэд одоо байгаа зээлийнхээ хугацааг 12 сараар сунгах болсон үндэслэл юу вэ?

Өмнө нь дурдсан дээр нэмж тодруулъя. Хямралын үед, эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал бий болсон үед бидний хэллэгээр эдийн засагт “Зээлийн тасалдал” бий болдог. Нэг ёсондоо санхүүгийн байгууллага өөрийнхөө үүрэх эрсдэлийг бага байлгахыг зорьдог.

■ ■ ■

ХАРИЛЦАГЧИЙН ХАДГАЛАМЖИЙГ ТАТААД, ЗЭЭЛ БОЛГОЖ БАЙГАА УЧРААС ХАРИЛЦАГЧИЙН МӨНГИЙГ ЭРСДЭЛГҮЙ БАЙЛГАХЫН ТУЛД ЗЭЭЛЭЭ ЭРСДЭЛГҮЙ БАЙЛГАХ ЁСТОЙ.

Энэ эрсдэлийг бууруулах үүднээс зээл гаргах шалгууруудаа чангатгаад, зээл олголт ороо эрс багасгадаг. Ийм нөхцөл байдал үүсэх эрсдэл байгаа учраас банкны зээл рүү татагдаад байгаа мөнгөн хөрөнгийг аль болох эдийн засагт нь үлдээх бодлогын арга хэмжээ авч байгаа юм.

Гуравдугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр бизнесийн болон хэрэглээний зээлийг 3 сараар хойшлуулах шийдвэр гаргасан. Үүнээс хойш арилжааны банкнүүдэд дөрөвдүгээр сарын эхээр авсан мэдээгээр 600 гаруй тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хуваарь, бүтцэд өөрчлөлт орсон байна.

■ Хугацаа сунгаж байгаа нь мэдээж тодорхой хэмжээнд эргэн төлөлт нь хүндэрч байгаа зээлүүдэд хамаарах байх. Зээлдэгч энэ боломжийг хэрхэн ашиглах вэ?

Хүндрэлд орсон зээл хамаарна. Зээлдэгч аль болох эрт банкандаа хүсэлтээ гаргах ёстой. Ажилгүй болсон, ажлын цаг багассан, эсвэл гэр бүлийн гишүүн ажилгүй болсон гэх зэрэг мэдээллээ арилжааны банкандаа өгнө. Ингэснээр зээлдэгч Монголбанкнаас олгож байгаа хугацаанд харьцангуй зээлийн дарамт багатай байх боломж бүрдэнэ.

Хэрэгжилтийн хувьд энэ маш том ажил болно. Тухайлбал, зээлдэгчийн тоо 1.2 сая байхын

зэрэгцээ олон хүн цуглуулахгүй байх, цахим хэлбэрээр зохион байгуулах гээд банкнүүд дээр ачаалал их байгаа.

■ Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаад Монголбанк тодорхой хэмжээний арга хэмжээ, шийдвэрүүдийг гаргаж байна. Цаашид юун дээр анхаарах вэ?

Нэгд, тодорхой бус байдал өндөр байгаа тул эдийн засгийн нөөц, бодлогын орон зайг аль болох хэмнэх, хамгаалах шаардлагатай. Хоёрт, манай эдийн засгийн дотоод идэвхжлийг эцэстээ гадаад урсгал тодорхойлох учраас гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, тухайлбал экспортоо сэргээх, 1 дүгээр улиралд алдсан экспортоо нөхөх. Гуравт, хөрш орнууд, донорууд, олон улсын санхүүгийн байгууллагуудтайгаа харилцаагаа эрчимжүүлэх. Дөрөвт, ААН, өрхийг дампуурал хүндрэлээс сэргийлэхийн зэрэгцээ өнгөрсөн хугацаанд бий болгосон бодлогын зарчмуудаа хадгалж хамгаалах, зах зээлийн үндсэн зарчмуудаа хадгалах нь чухал гэж бодож байна.

Ярилцсанд баярлалаа.



ХОЛБООТОЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТУУД

Монголбанкнаас гаргасан шийдвэрийн дагуу иргэд хэрэглээний зээлийнхээ гэрээнд өөрчлөлт оруулж, хугацааг сунгах боломжтой болсон. Гэвч энэ шийдвэр банкнуудад хэрэгжихгүй байна гэх гомдол их байна.

Уг шийдвэрийн хэрэгжилт хэр зэрэг хангалттай байна вэ?

- 2020 оны 3-р сарын 17-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлийн хувьд хуваарийн дагуу эргэн төлөлт хийлгүй 15 хоногоос хэтэрсэн тохиолдолд зээлийн чанарыг бууруулдаг байсныг 90 хоног хүртэл сунгах шийдвэрийг гаргасан.

Харин Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4-р сарын 13-ны хуралдаанаар хэрэглээний зээлд мөрдөгдөх өр, орлогын харьцаа (60%)-ны болон хугацаа (30 сар)-ны дээд хязгаараас шалтгаалан нөхцөл

өөрчлөх боломжгүй байгаа, эргэн төлөлтийн хүндрэлд орчихсон байгаа хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар 1 удаа сунгах боломжийг банкнууд болон зээлдэгчдэд олгож байна.

Энэ шийдвэр нь 4 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. Өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаарын хүрээнд байгаа зээлүүдийн хувьд зээлийн гэрээний нөхцөлөө өөрчлөөд явж байгаа.

Дээрх шийдвэрийн хүрээнд хэрэглээний зээлийн хугацааг сунгахад зээлийн үлдэгдэл дүнд өөрчлөлт орох уу?

- Зээлдэгч банктайгаа тохиролцон зээлийн хугацааг сунгахдаа үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж буй хугацаанд хүүний төлбөрийг төлөхгүйгээр хойшлуулсан тохиолдолд хуримтлагдсан хүүний төлбөрийг үлдэгдэл хугацаанд тархаан байршуулах (хүүг капиталжуулах) дүнгээр өсч болно. Бусад тохиолдолд өөрчлөлт орохгүй.

Зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж, хугацааг сунгахад иргэд ямар материал бүрдүүлэх ёстой вэ?

- Иргэдийн орлого тасалдаж, зээлийн эргэн төлөлтийг хийхэд хүндрэл учирсан зээлдэгчид банканд хүсэлтээ гарган нөхцөлөө өөрчлөх боломжтой. Банкны зүгээс байгууллагын тодорхойлолт эсвэл дансны хуулга болон бусад холбогдох материалууд дээр үндэслэн орлого тасалдсаныг тогтоож болно.

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг зээлийн төлөлтийг царцаах гэж ойлгох тал байна. Дээрх шийдвэрийн гол агуулга нь юу вэ?

- Эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор иргэдийн орлого буурч, хэрэглээний зээлийн эргэн төлөлт саатах эрсдэл бий болж байгаа тул системийн тогтвортой байдлыг хангахын тулд зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн санхүүгийн

чадавхтай уялдуулах шаардлага үүссэн. Иймд нөхцөлийг нь өөрчлөх шаардлагатай хэрэглээний зориулалттай зээлийн хувьд хугацааг нь 12 сараар сунган эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэх боломжийг банкнууд болон зээлдэгчдэд олгож байгаа. Энэ арга хэмжээ нь нэг удаагийн арга хэмжээ бөгөөд хэвийн зээлийн ангиллыг өөрчлөхгүй байх 90 хоногийн хугацаанд (7-р сарын 31-нийг хүртэл) багтаан банкнууд зээлдэгчид тохиролцон эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэх юм. Энэхүү арга хэмжээний үр дүнд зээлдэгчдийн зээлийн сарын төлбөр буурч, зээлдэгчийн гар дээр үлдэх орлого нэмэгдэнэ.

Банкнүүдэд албан ёсны шийдвэрийг хүргүүлсэн үү? Бодлогын шийдвэр гаргалт, түүний хэрэгжилтийн уялдаа, холбоог хэрхэн хангаж байна вэ?

- Мөнгөний бодлогын хорооны дээрх шийдвэрийн тогтоол дээр үндэслэн Монголбанкны ерөнхийлөгч тушаал гаргаж банкнүүдэд хүргүүлсэн. Тиймээс хэрэглээний зээлийн хугацааг сунгах, нөхцөл өөрчлөх шийдвэр нь 4-р сарын 14-ний өдрөөс эхлэн бүх банкнууд дээр хэрэгжээд явна.

Хэрэглээний зээл авсан бүх зээлдэгчид зээлийн үлдэгдэл хугацааг 12 сараар сунгах уу?

- Зөвхөн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас (i) зээлийн эргэн төлөлт доголдсон, (ii) орлого нь буурч, зээлийн анхны гэрээний дагуу зээлийн төлбөрийг төлөх боломжгүй болсон зээлдэгчдийн хувьд энэхүү хөнгөлөлтөд хамрагдах юм. Харин орлогын хэмжээнд өөрчлөлт ороогүй бөгөөд зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх боломжтой зээлдэгчдийн хувьд

энэ хөнгөлөлт хамраахгүй.

Хэрэглээний зээл авсан зээлдэгчийн орлого буураагүй ч өрхийн гишүүн нь түр хугацаанд ажилгүй болж, орлогогүй болсон тохиолдолд энэ хөнгөлөлтөд хамрагдах боломжтой юу?

- Боломжтой. Гэхдээ зээлдэгч нь нэгдүгээрт, ажилгүй болсон иргэнийг өөрийн өрхийн гишүүн гэдгийг, хоёрдугаарт, тухайн өрхийн гишүүн нь түр хугацаанд ажилгүй болсныг нотлох шаардлагатай.

Хэрэглээний зээлд ямар төрлийн зээлийн бүтээгдэхүүнүүд багтдаг вэ?

- Өрх гэр, иргэдийн хувийн хэрэгцээнд зориулагдсан зээлийн бүтээгдэхүүнийг хэрэглээний зээл гэж ойлгож болно. Тодруулбал, цалингийн зээл, тэтгэврийн зээл, малчны зээл, автомашины зээл, лизинг, кредит картын зээл болон дээрхтэй төстэй бусад зээлийн гэрээ, хэлцлийг хэрэглээний зээлд хамруулдаг.

Зээлдэгч зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд заавал 12 сараар зээлийн хугацааг сунгах уу?

- Үгүй. Зээлдэгч нь банктайгаа тохиролцож зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд 12 сар хүртэлх хугацаагаар зээлийн үлдэгдэл хугацааг сунгаж болно.

Зээлдэгчийн өр, орлогын харьцаанд өөрчлөлт орох уу?

- Тийм. Учир нь зээлдэгч зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулах бүрт өр, орлогын харьцааны тооцооллыг шинэчлэх шаардлагатай байдаг. Банкны зүгээс таны банк болон бусад

санхүүгийн байгууллагад төлөх өглөгийг, орлогод харьцуулан тооцоолно.

Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахад өр, орлогын харьцаа нь 60 хувиас өндөр байгаа зээлүүдийн хувьд хугацаа сунгаж болох уу?

Болно. Ялангуяа өмнө нь өндөр Өр орлогын харьцаагаар авсан зээлүүдийг 12 сараар сунгасан ч Өр орлогын харьцаа нь 60 хувиас давах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй.

Хэрэглээний зээлийн үлдэгдэл хугацааг 12 сараас урт хугацаагаар сунгах боломжтой юу?

Зөвхөн Монголбанкнаас тогтоосон хугацаа (30 сар) болон өр, орлогын харьцааны (60 хувь) хязгаарлалтын хүрээнд боломжтой. Жишээлбэл, зээлийн хугацаа 10 сар, зээлдэгчийн өр, орлогын харьцаа 60 хувиас бага тохиолдолд банк болон зээлдэгчид тохиролцон зээлийн үлдэгдэл хугацааг 20 хүртэлх сараар сунгах боломжтой юм.

Харин Монголбанкнаас тогтоосон макро зохистой бодлогын хязгаарлалтуудын хүрээнд нөхцөлийг нь өөрчлөх боломжгүй зээлүүдийн хувьд зээлийн үлдэгдэл хугацааг зөвхөн 12 хүртэлх сараар 1 удаа сунгах боломжтой.

Зээлийн хугацааг 12 сараар сунгахдаа хүүний төлбөрийг 3 сараар хойшлуулсан тохиолдолд нийт 15 сараар зээлийн үлдэгдэл хугацаа уртасна гэсэн үг үү?

Үгүй. Макро зохистой бодлогын хязгаарлалтуудын хүрээнд нөхцөлийг нь өөрчлөх боломжгүй зээлүүдийн хувьд зээлийн хугацааг сунгах нийт хугацаа 12 сараас хэтрэхгүй бөгөөд 3 сараар хойшлуулж байгаа нь 12 сардаа багтана.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



**МОНГОЛЫН
ИПОТЕКИЙН
КОРПОРАЦИ ОССК**
ХЭЗГААРЛАГДАЛ ХАРИУЦАГАТАЙ КОМПАНИ

ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХҮҮТЭЙ ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТҮР ХОЙШЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТУУД

Энэ арга хэмжээнд ямар зээлдэгч хамрагдах вэ?

Энэхүү арга хэмжээнд Төрөөс санхүүжүүлж буй орон сууцны ипотекийн 8 болон 5 хувийн хүүтэй зээл авсан иргэд хамрагдана.

Ипотекийн зээлийн төлбөрөө хэвийн төлж байгаа зээлдэгч төлбөрөө хойшлуулах боломжтой юу?

Ипотекийн зээлийн төлбөрөө хэвийн төлж байгаа зээлдэгч төлбөрөө хойшлуулж болно. Зээлдэгч харилцагч банкандаа хүсэлт гарган, зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулснаар дараагийн төлбөрийн хуваарьт өдрөөс эхлэн 6 хүртэл сараар зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулна.

Зээлийн төлбөрийн хугацаа хэтэрсэн зээлдэгчийн хувьд төлбөрөө хойшлуулж болох уу?

Зээлийн төлбөрт нь 2020 оны 1 сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгч төлбөрөө хойшлуулж болно. Жишээлбэл, зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд 2020 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс доголдол үүссэн бол зээлдэгч хүсэлт гарган, гэрээнд өөрчлөлт оруулсны үндсэн дээр 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл төлбөрөө хойшлуулна.

Зээлдэгч хэдэн удаа төлбөрөө хойшлуулж болох вэ?

Зээлдэгч зөвхөн нэг удаа 6 хүртэл сараар үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулж болно.

Зээлийн төлбөрийг хойшлуулахад ямар баримт материал, нотолгоо бүрдүүлэх шаардлагатай вэ?

Зээлдэгчийн зүгээс нэмэлт баримт материал, орлогын нотолгоо шаардлагагүй бөгөөд харилцагч банкандаа 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хүсэлт гарган, зээлийн гэрээний эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэн байгуулсан байх шаардлагатай.

Зээлийн төлбөрийг хойшлуулахтай холбогдуулан зээлийн гэрээг шинэчлэхэд зээлдэгчийн өр орлогын харьцаа, зээлийн хугацааны дээд хязгаар зэрэг зохицуулалтуудыг мөрдүүлэх үү?

Энэхүү арга хэмжээний хүрээнд өр, орлогын харьцаа, зээлийн хугацааны дээд хязгаар зэрэг Монголбанк, Сангийн яам болон бусад холбогдох байгууллагуудаас тогтоосон зохицуулалтууд, хязгаарлалтуудыг мөрдүүлэхгүй.

Зээлийн төлбөрийн хугацааг хойшлуулснаар сард төлдөг зээлийн төлбөр өөрчлөгдөх үү? Сард төлдөг байсан зээлийн төлбөрт өөрчлөлт орохгүй бөгөөд төлбөрийг 6 сар хойшлуулсны дараа 7 дахь сараасаа хуучин төлдөг байсан дүнгээр төлбөрөө үргэлжлүүлэн төлнө.

Зээлийн төлбөрийг хойшлуулсан хугацаанд ямар

нэг хүүгийн төлбөр төлөх үү? Зээлийн хугацаанд өөрчлөлт орох уу?

Зээлийн төлбөр хойшлуулсан хугацаанд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөхгүй бөгөөд хойшлуулсан хугацаагаар зээлийн хуваарийг уртасгана. Жишээлбэл, зээлийн гэрээ 2030 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр дуусах байсан бол төлбөрийг хойшлуулснаар гэрээний хугацаа 6 сараар сунгагдаж, 2030 оны 7 дугаар сарын 30-ны өдөр дуусна.

Энэхүү арга хэмжээнээс өмнө зээлдэгчийн төлбөрт доголдол үүссэнтэй холбогдуулан ногдуулаад байсан нэмэгдүүлсэн хүүг банкнууд харилцагчдаа буцаан олгох уу?

МИК ОССК ХХК-иас нэмэгдүүлсэн хүүг ямар хэлбэрээр банкны харилцагчдад буцаан олгох талаар ойрын хугацаанд банкнуудад чиглэл өгөхөөр ажиллаж байна.

Зээлдэгч төлбөрөө хойшлуулснаар зээлийн ангилалд өөрчлөлт орох уу?

Монголбанкаас 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдөр "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д холбогдох өөрчлөлтийг оруулж, 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдүүлэхээр болсон тул зээлдэгч төлбөрөө хойшлуулснаар зээлийн ангилалд ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Гэхдээ зээлийн гэрээний өөрчлөлтийг Зээлийн мэдээллийн санд бүртгэнэ.

ШАР БОЛОР



БОХИР ЖИН: 91.54 ГР

ЦЭВЭР ЖИН: 31.538 ГР

32.3 X 32.1 X 20.8 ММ


КАРАТ: 91538

ЭНЭХҮҮ 500 ГРАММ ЖИНТЭЙ ЭРДЭНИЙН ЧУЛУУГ ХЭНТИЙ АЙМГИЙН БИҮНДЭР СУМААС НУТГИЙН МАЛЧИН Р.СУГАР ОЛЖ, 2002 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД "OPEL GEMS" КОМПАНИД БЭЛЭГЛЭСЭН БАЙНА. ТУНГАЛАГ ШАРГАЛ ӨНГӨТЭЙ ТАЛСТ ГАРГАЖ ЗАССАН ЭНЭХҮҮ ЧУЛУУГ 2002 ОНЫ 10 ДУГААР САРД СОРЬЦЫН УЛСЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ЭРДЭНЭСИЙН ЧУЛУУНЫ ЛАБОРАТОРИД ШИНЖИЛЖ, ШАР БОЛОР БОЛОХЫГ ТОГТООЖЭЭ. УГ БОЛОРЫГ 2002 ОНЫ 3 ДУГААР САРД МАСТЕР ТАЛСТ ЗАСАЛЧИН С.АЛТАНДӨШ "DEVEEIS" КОМПАНИЙ ТОП ЖЕЙМ ДИЗАЙНЫ ШАГНАЛ ХҮРТСЭН ЗУРГААН ТАЛСТ "HEXAGON VARI-ON" ХЭМЭЭХ ЗАСАЛТААР ЗАСЖЭЭ. МОНГОЛ ОРНООС ОЛДСОН, ЭНЭХҮҮ ГАЙХАМШИГТ ХОВОР АЛТЛАГ ӨНГӨТЭЙ, ШАР БОЛОР НЬ ДАХИН ДАВТАГДАШГҮЙ УР ХИЙЦТЭЙ, ДЭЛХИЙН ЧАНАРЫН СТАНДАРТАД ХҮРСЭН МАСТЕР АЖИЛ БОЛЖЭЭ.




1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)



Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- **M2 мөнгөний жилийн өсөлт 3.8% болж, 20.5** их наяд төгрөгт хүрэв. Жилийн өсөлтийн **4.0** нэгж %-ийг гадаад валютын хадгаламж, **3.0** нэгж хувийг гадаад валютын харилцах, **0.2** нэгж %-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, **-0.8** нэгж %-ийг төгрөгийн харилцах, **-2.2** нэгж %-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн байна.




- **M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.8** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **2.6** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл **17.0** их наяд төгрөг (төгрөгийн зээл **15.1** их наяд, гадаад валютын зээл **1.9** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **1.2%**-иар, өмнөх оны мөн үеэс **2.0%**-иар буурлаа.
- Чанаргүй зээл өмнөх сараас 9 тэрбум төгрөгөөр буурч, нийт зээлд эзлэх хэмжээ **10.7%** болов.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 120 тэрбум төгрөгөөр өсч, нийт зээлд эзлэх хэмжээ **6.7%** болов.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Зураг 3.2. Тайлант сард олгосон ипотекийн зээлийн хүү




- Тайлант сард банкууд **613** зээлдэгчид **46.6** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **42.7%** нь хөтөлбөрийн, **57.3%** нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


- Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс **1.5** нэгж хувиар буурч, өмнөх сараас **0.7** нэгж хувиар өсч **11.5%**-д хүрсэн байна.

4. Хүү

Зураг 4.1. Шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. Шинээр олгосон зээлийн хүү



- 2020 оны 3 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) **11.1%**, гадаад валютын хадгаламжийн ЖДХ **5.4%**-д хүртээ. Төгрөгийн ЖДХ өмнөх оны мөн үеэс **1.6** нэгж %-иар буурав.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **16.6%**, гадаад валютын ЖДХ **10.5%**-д хүрч шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс **0.5** нэгж %-иар буурав.

*Хотолборийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаасгүй болно.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 3 сар /урьдчилсан/



БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

ӨНГӨРСӨН 2 САРЫН ХУГАЦААН ДАХЬ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

	ААН-ийн	Иргэдийн
Зээлийн шалгуур	Нийт банкууд зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан байна.	Нийт банкууд зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан байна.
Зээлийн нөхцөл	Банкууд хүүний бус шимтгэлийг бага зэрэг бууруулахаас бусад байдлаар зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулаагүй байна.	Банкууд зээлийн нөхцөлд төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна.
Зээлийн эрэлт	Банкуудын худалдаа, үйлчилгээний салбараас бусад салбарт олгосон зээлийн эрэлт бага зэрэг буурсан байна.	Банкуудын иргэдэд олгосон зээлийн эрэлт бага зэрэг буурсан байна.

ИРЭХ 1 САРЫН ХУГАЦААН ДАХЬ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

	ААН-ийн	Иргэдийн
Зээлийн шалгуур	Банкууд ААН-д олгох зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах төлөвтэй байна.	Жижиг банкнаас бусад банкууд зээлийн шалгуураа өөрчлөх төлөвтэй байна.
Зээлийн нөхцөл	Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахааргүй байна.	Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахааргүй байна.
Зээлийн эрэлт	Том банкууд зээлийн эрэлтийг бага зэрэг буурна гэж хүлээж байгаа бол бусад банкууд бага зэрэг өснө гэсэн хүлээлттэй байна.	Иргэдэд олгох зээлийн эрэлт бага зэрэг буурна гэсэн хүлээлттэй байна.

Зээлийн шалгуур (Credit standards): Зээлдэгчийг зээлийн шаардлага хангах эхлэлийг тодорхойлдог банкны дотоод журам, аргачлал, процедур. Тухайлбал, зээлдэгчийн өр орлогын харьцааг тооцож, тодорхой хязгаар заах.

Зээлийн нөхцөл (Credit terms and conditions): Зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүр, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно.

Ковид-19 нар гахлаас шалтгаалсан эдийн засгийн өсөлтийн сааралт, бизнесийн идэвхжил суларсан зэрэг нь ААН болон иргэдэд олгох зээлийн эргэлт төлөлт муудалд сөргөөр нөлөөлж байгааг ихэнхи банкууд онцоллоо.

Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгаа 2020 оны 4 дүгээр сар, Монголбанк

2020 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРД

1.4 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны 4 дүгээр сард 1.4 тн үнэт металл худалдан авсан бөгөөд оны эхний өссөн дүнгээр нийт 6.7 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 дахин өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 6.7 тн үнэт металлын 5.0 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна. 2020 оны 4 дүгээр сарын байдлаар Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 15.9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 74.5 кг үнэт металл худалдан аваад байна.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 4 дүгээр сард **149,986.18** төгрөг байлаа.


Зураг 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Зураг 2. 2020 оны 4 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)




Зураг 3. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

Банк хоорондын валют арилжааны цахим талбарыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2020/04/28-ны хооронд 2,092.3 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1455 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

ТоС Холбооны төсөл ба хамтын ажиллагааны
менежер **Э.НАНДИН-ЭРДЭНЭ**



Тогтвортой санхүүжилтийн тухай ойлголт нь харьцангуй шинэ хэдий ч манай улс, ялангуяа дотоодын арилжааны банкнууд тогтвортой санхүүжилтийг нэгдсэн байдлаар үйл ажиллагаандаа хэрэгжүүлээд 7 жилийг ардаа үдээд байна.

Тогтвортой санхүүжилт буюу ТоС хөтөлбөрийн суурь нь 2013 онд анх зохион байгуулагдсан ТоС Форумаас эхлэлтэй бөгөөд уг форумын дараа Монголын Банкны Холбоо, түүний гишүүн банкнууд, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нидерландын Хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Монгол Улсын ногоон эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах зорилгоор 2013 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүгийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-т гарын үсэг зурж, “Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн түүхтэй билээ. ТоС хөтөлбөрийн хүрээнд байгаль орчин, нийгмийн хувьд дунд болон өндөр эрсдэлтэй салбарууд болох уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудад баримтлах тогтвортой санхүүжилтийн удирдамж¹, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний аргачлал, ТоС-ийн 8 зарчим² зэрэг баримт бичгүүд, хэрэгслүүд боловсруулагдаж бүх арилжааны банкнууд эдгээр зарчим, удирдамж, аргачлалыг сайн дураараа үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, аливаа зээл санхүүжилтийн шийдвэр гаргахаасаа өмнө харилцагчийн зөвхөн санхүүгийн эрсдэлийг бус байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг тооцоолон үүний үндсэн дээр санхүүжилт олгох эсэх шийдвэрийг гаргадаг болсон. Тогтвортой санхүүжилтийн хамрах цар хүрээ нь зөвхөн банк, санхүүгийн салбараар хязгаарлагдахгүй

маш өргөн учраас ТоС Хөтөлбөр нь тогтвортой санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх, бодит нөлөөг нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсыг тогтвортой санхүүгийн бус нутгийн төв болгох гэсэн алсын хараатайгаар 2017 оны 12 сард ТоС Холбоо бүх арилжааны банкнуудыг гишүүнээр элсүүлэн, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Уур амьсгалын өөрчлөлт сүүлийн арван жил маш хурдацтай өсөж, тэгш бус байдал дэлхийд хэзээ ч байгаагүй хэмжээнд хүрч, улс орнуудын хоорондох болон улс доторх орлогын ялгаатай байдал газар авч, байгаль орчны бохирдол нэмэгдэж, энэ бүхний үр дүнд хүний эрх, хүүхдийн эрх зөрчигдөж, жендерийн асуудал ч орхигдуулахын аргагүй болж байна. Дэлхий тэр чигээрээ өөрчлөгдөж байхад санхүүгийн салбар өөрийн чиг үүргийн хүрээнд энэ бүх тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах нь нэн шаардлагатай. Саяхныг хүртэл санхүүгийн байгууллагууд санхүүжилт хүсэж буй харилцагчаасаа “танай бизнесийн ялгаруулж буй нүүрсхүчлийн хэмжээ хэр их вэ?, танай байгууллагын удирдах албантушаалтны хэдэн хувь нь эмэгтэй вэ?, танай бизнес/төсөл шууд болон шууд бус байдлаар нутгийн уугуул иргэд, соёлын өвд нөлөө үзүүлэх үү?” гэж асууж, үнэлгээ хийж байсан нь ховор. Харин тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлнэ гэдэг нь харилцагчийн санхүүгийн үзүүлэлтээс гадна байгаль орчин, нийгмийн үзүүлэлт, нөлөөллийг үнэлэх, эрсдэл бууруулах арга хэмжээг харилцагчид зөвлөх, харилцагчийн бизнесийг нэмүү өртгийн сүлжээгээр бүхэлд нь харж дүгнэх, харилцагчаас тогтвортой байдлын тайлан авах, санхүүгийн байгууллага нь өөрөө үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй явуулах, ил тод тайлагнах, бусдадаа үлгэрлэн манлайлах,

¹ <http://toc.mn/category/41>

² <http://toc.mn/principles#1>

ээрэг нөлөө бүхий санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхийг хэлнэ. Банк, санхүүгийн байгууллага тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэх эхний алхам нь харилцагчийн зээл, санхүүжилтийн өргөдөлд байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээ хийх, үүний дараа ногоон санхүүгийн бүтээгдэхүүнээр дамжуулан байгаль, нийгэмд ээлтэй бизнесүүдийг болон өрхийн хэрэглээг дэмжих, эцэст нь энэ бүх тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийсэн ажлууд, байгаль орчин, нийгэм, тогтвортой хөгжлийн зорилгод оруулсан хувь нэмрээ ил тод, тогтмол тайлагнаж, бусдыгаа уриалах, манлайлах, бусад салбаруудад сайн жишээ болох явдал билээ. 2019 оны 12 дугаар сард Монгол Улс нь АНУ, Европын орнуудаас ч өмнө ногоон таксономио³ баталсан дэлхийн 2 дахь улс болов. Цөөн үгээр тайлбарлавал, ногоон таксономи нь ногоон гэх тодорхойлолт буюу ногоон үйл ажиллагааны ангилал бөгөөд энэ нь санхүүгийн байгууллагуудад ногоон зээл, ногоон бонд гаргах гол хэрэгсэл нь болж ашиглагдах юм. Ийнхүү ногоон таксономийн ангиллын дагуу арилжааны банкнуудаас сайн дурын үндсэн дээр ногоон зээлийн тайлан авахад, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар сэргээгдэх эрчим хүч, бага бохирдуулагч эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон барилга, бохирдлоос сэргийлэх үйл ажиллагаа, тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой хамгаалал, эко аялал жуулчлал, тогтвортой ус, хаягдлын хэрэглээнд хамаарах нийт 388.7 тэрбум төгрөгтэй тэнцэх 967 ногоон зээл арилжааны банкнуудаар дамжин олгогджээ. Энэ нь банкны салбарын нийт зээлийн үлдэгдлийн 2.27 хувийг эзэлж буй юм⁴.

Арилжааны банкнууд сайн дурын үндсэн дээр ТоС Холбоонд хагас жил тутамд ТоС-ийн тайлан⁵ ирүүлдэг бөгөөд, 2013 оноос хойших ТоС-ийн тайлангуудыг нэгтгэн харахад тун сонирхолтой статистик гарсан нь:

- 7678 зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийгдсэн;
- Ойролцоогоор 21 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц

45 зээлийн хүсэлт байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй, сөрөг нөлөөтэй гэсэн шалтгаанаар санхүүжүүлэгдэхээс татгалзсан;

- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлд нийт 41.5 тэрбум төгрөгийн 5 зээл, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн 69.2 тэрбум төгрөгтэй тэнцэх 255 зээл, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн 36.5 тэрбум төгрөгийн 2326 зээл, усны хэмнэлт, цэвэршүүлэлттэй холбогдох 550 сая төгрөгийн 5 зээл, биологийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэсэн 1.3 тэрбум төгрөгийн 116 зээл, байгаль орчны хамгааллын чиглэлээр 18.2 тэрбум төгрөгтэй тэнцэх нийт 55 зээл дотоодын арилжааны банкнуудаар санхүүжигдсэн байна.

Тогтвортой Банкны Холбоо нь 2012 оноос хойш ОУСК-ын дэргэд үйл ажиллагаа явуулж буй 38 гишүүн орноос бүрдсэн сайн дурын холбоо бөгөөд 2017 оноос гишүүн орнуудын тогтвортой санхүүжилтийн явцын тайланг жил бүр гаргадаг болсон. ТБХ-ны 2019 оны Глобал явцын тайландб дурдагдсанаар Монгол Улс нь тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн шатанд амжилттай явж буй гэж үнэлэгджээ.



Зураг 1. SBN-ийн гишүүн орнуудын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн явц.

³ <http://toc.mn/post/116>

⁴ Монголбанкны ногоон зээлийн урьдчилсан тайлан, 2019 оны 3-р улирал

⁵ 2013 оноос эхлэн ТоС Хөтөлбөрт нэгдэж, тунхаг бичигт гарын үсэг зурсан гишүүд банкнууд (бүх банк) ТоС Холбоонд хагас жил тутам тогтвортой санхүүжилтийн тайланг сайн дураар ирүүлдэг.

⁶ https://www.ifc.org/wps/wcm/connect/227d98d4-13ae-4742-ae94-fb248b84f0be/SBN%2BGlobal%2BProgress%2BReport_1010.pdf?MOD=AJPERES&CVID=mUhlWWP

ОУВС, ДЭЛХИЙН БАНКНЫ 2020 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ



Жил тутам зохион байгуулагддаг ОУВС, Дэлхийн банкны хаврын ээлжит чуулга уулзалт энэ удаад онцгой нөхцөл байдалд 4-р сарын 17-оос 19-ний өдрүүдэд боллоо. Уг чуулга уулзалтаар гишүүн улсуудын Төв банкны тэргүүнүүд,

Сангийн сайд нар, парламентын гишүүд, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн шинжээч нар, бизнесийн болон хэвлэлийн төлөөлөгчид оролцож, дэлхийн эдийн засгийн хандлага, үүсээд буй сорилт бэрхшээлүүд, ядуурал нийгмийн асуудлууд, эдийн засгийн хөгжил, тусламж санхүүжилтийн үр ашигтай байдал зэрэг сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлгүүд өрнүүлдэг. Уулзалт уламжлал ёсоор АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагддаг боловч КОВИД-19 цар тахлын улмаас анх удаагаа цахим хэлбэрээр боллоо.

Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын тайлан

ОУВС, Дэлхийн банкны чуулга уулзалтуудын үеэр хэд хэдэн чухал тайланг танилцуулдаг бөгөөд тэдгээрийн цөм болсон Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын тайлангийн ээлжит дугаарыг урьдчилж танилцуулсан.

Энэ удаагийн дугаарыг үүсээд байгаа нөхцөл байдал, хямралын нэрээр “Их хорио” нэртэйгээр гаргасан ба дэлхийн эдийн засагт сүүлийн 100 жилд тохиогоогүй ихээхэн хохирол бий болохоор байгааг анхааруулж, нийт эдийн засаг 2020 онд 3 хувиар агших төсөөллийг гаргажээ. 1 сард түгээгдсэн өмнөх тайланд 2020 оны өсөлтийг 3.3 хувь байхаар төсөөлж байсан билээ.

Ер нь дэлхийн эдийн засагт хамгийн их нөлөөтэй 100 улсаас зөвхөн БНХАУ-ын эдийн засагт 1.2 хувь, Энэтхэгийн эдийн засагт 1.9 хувь тус тус өсөхөөр байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт аж. Тэгвэл АНУ-ын эдийн засаг 5.9 хувь агших, Евро бүс нийтдээ 7.5 хувиар агших, Ойрхи Дорнод болон Төв Ази 2.8 хувийн бууралт үзүүлэх, Азийн хөгжиж буй 23 орнууд нийт 1 хувь өсөх, Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд 5.2 хувийн агшилттай байхаар байна.



ОУВС, Дэлхийн банкны тэргүүнүүд

Чуулга уулзалтын үеэр ОУВС-ийн тэргүүн Кристалина Георгиева 2020 онд дэлхийн 170 улсад нэг хүнд ногдох орлого буурахаар байгааг анхааруулав. ОУВС-аас 102 улс тусламж хүсээд байгаа бөгөөд 4-р сард 50%-ийг нь шийдвэрлэнэ гэж мэдэгдсэн. Мөн гишүүн орнуудаас бүрдүүлсэн Гамшгаас хамгаалах, тусламжийн сан болон Ядуурлыг бууруулах, өсөлтийн итгэлцлийн санхүүжилтээр 17 тэрбум ам.долларын дэмжлэгийг ядуу, буурай гишүүн орнууддаа үзүүлэх аж. ОУВС нөөц бололцоогоо 2 дахин нэмэгдүүлж, 100 тэрбум ам.долларт хүргэсэн. Кристалина Георгиева асуудлыг даван туулах санхүүжилтүүдийг олгохын зэрэгцээ эдийн засгийг сэргээхэд чухал бодлогын арга хэмжээнүүдийг улс орон болгон авч хэрэгжүүлэх ёстойг тэмдэглэв.

Өнгөрсөн онд Дэлхийн банкны тэргүүнээр сонгогдсон Дэвид Малпасс “2019 онд бид Хөгжлийн зөвлөлийн хурлыг 100 дахь жилдээ зохион байгуулж байх үед дэлхийн эдийн засаг, түүнд тулгарч буй асуудал, сорилтууд тэс өөр байлаа. Өдгөө бид эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн тэс өөр хямралтай нүүр тулаад байна” гэв. Дэлхийн банкнаас КОВИД-19 хөтөлбөрийн хүрээнд 64 хөгжиж байгаа орнуудад дэмжлэг үзүүлээд байгаа ба энэ тоо 4-р сарын эцэс гэхэд 100-д хүрэхээр байна. Тэрбээр өнөөгийн нөөц бололцоо, хөшүүргийг ашиглаж, ирэх 15 сарын турш 160 тэрбум ам.долларын санхүүжилтийг олгох боломжтойг мэдэгдэв. Мөн Дэлхийн банк группд багтдаг Олон улсын хөгжлийн холбоогоор дамжуулж 50 тэрбум ам.долларын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийг олгоно.

Дэд хурал, хэлэлцүүлгүүд

Энэ удаагийн чуулга уулзалтаар Их 7-гийн Сангийн яам, Төв банкны тэргүүнүүдийн хэлэлцүүлэг, Их 20-ийн уулзалт, иргэний нийгмийн байгууллага бодлого боловсруулагчдын уулзалт, вакцин хөгжүүлэлт болон эрүүл мэндийн секторын уулзалтууд болон бүс нутгийн уулзалт, хэлэлцүүлгүүд онлайн боллоо. Энэ удаа хөндөгдсөн дийлэнх сэдвүүд яах аргагүй Ковид-19 цар тахал болон түүнээс үүдэлтэй эдийн засгийн хүндрэлтэй холбогдож байлаа. Өнөөгийн

байдлаар Дэлхийн улс орнууд нийт \$8 их наяд буюу дэлхийн ДНБ-ий 9.5%-тай тэнцэх төсвийн дэмжлэгийн багцыг батлаад байна. Улмаар засгийн газруудын өрийн түвшин 13 нэгж хувиар нэмэгдэж, ДНБ-ий 96%-д хүрэхээр байгаа. КОВИД-19 вирусийн үеийн онцгой нөхцөл байдалд тохирсон онцгой төсвийн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал хэдий ч, сайн засаглал болон санхүүгийн сахилга бат, хариуцлага чухал болохыг ОУВС-аас онцлов.

Түүнчлэн хөгжсөн болон хөгжиж буй орнуудын хувьд гадаад валюттай харьцах ханшийн савлагаа өндөр, бодит үйлчилж буй ханш +/-20% дотор хэлбэлзэж байна. Хөгжиж буй орнуудаас гадагшлах хөрөнгийн урсгал 3 сарын дотор 100 тэрбум ам.доллар (ДНБ-ий 40%) буюу түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрлээ. Холбооны нөөцийн банк зэрэг гол төв банкнууд 6 их наяд ам.долларын багцыг зарлаад байгаа нь хөрөнгө оруулагчдын ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтийг тогтворжуулах нөлөөг үзүүлж байгааг эдийн засагчид онцолж байна. Гэвч олон улсын нөөцийн валюттай гол эдийн засгуудтай харьцуулахад Ази, Номхон далайн бүс нутгийн төсөв мөнгө, санхүүгийн бодлогын орон зай хязгаарлагдмал бөгөөд хөрөнгийн урсгал өндөр савлагаатай байгаа нь эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахыг энэ үеэр анхаарууллаа.

Ийнхүү ОУВС, Дэлхийн банкны хаврын ээлжит чуулга уулзалт мэдээллийн технологийн тусламжтайгаар амжилттай болж өндөрлөлөө. Цаашид хийгдэх ажлуудын үр дүн, далайцыг гишүүн орнуудын хамтын ажиллагаа, санхүүжилтийн тогтолцоо тодорхойлох бөгөөд улс тус бүр макро бодлогын арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлэн, санхүүгийн, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахын төлөө ажиллахыг уриаллаа.

Эх сурвалж:

Transcript of the 2020 Spring Meetings IMFC Press Conference

World Bank Group President Malpass: Remarks to the Development Committee

World Bank/IMF Spring Meetings 2020: Development Committee Communiquy

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 26/III ӨДРИЙН БАЙДЛААР)





Л.Болормаа: ХӨГЖЛИЙН БОДЛОГОО ДОР ХАЯЖ 10 ЖИЛ ТОГТВОРТОЙГООР ХЭРЭГЖҮҮЛМЭЭР БАЙНА

Эдийн засагч Л.Болормаатай ярилцлаа.



Болормаа нь Монголын анхны итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч /CFA/ BFAS ХХК санхүүгийн зөвлөх үйлчилгээний компанийн Гүйцэтгэх Захирал

Тэрээр банк, санхүүгийн салбарт 23 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд Голомт Файнэншил Группийн Гүйцэтгэх Захирал, Голомт Капитал ҮЦК-ний ТУЗ-ын дарга, Голомт банкны Хөрөнгө оруулалтын банк хариуцсан Тэргүүн дэд захирал, Монгол Улсын Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирал, "Дойче банк"-ны Нью Йорк болон Токио хотын салбаруудад дэд ерөнхийлөгч болон Ардын банкны Олон улсын үйл ажиллагаа хариуцсан газрын орлогч захирал / Гадаад валютын хэлтсийн захиралаар ажиллаж байсан.



Танай байгууллагын гол үйлчлүүлэгчдийн хувьд ихэвчлэн ямар салбарыг хамарч байна вэ?

Ихэвчлэн стратегийн зөвлөлөгөө авах гэсэн жижиг, дунд үйлдвэрлэгчид байдаг. Манай компанийн хувьд банк, санхүүгийн системийн хоёр том төсөлд оролцсон байдаг. Нэгдүгээрт, Монгол улсын хөгжлийн банкны концепц. Энэ нь бидний хувьд бараг хамгийн анхны бүтээгдэхүүн болж гарч байсан. Энэ концепц нь Их Хурлаар батлагдаж улмаар энэхүү банкыг

байгуулах, удирдах санал тавьснаар би 2011 оны 4 сарын 27-нд Хөгжлийн банкны тэргүүн дэд захирлаар томилогдож анхны ажилтан нь болж байсан. Зөвлөх үйлчилгээний компаниудын хувьд захиалагч нь "Манайд төсөл хэрэгжүүлэх шаардлага байна. Танай концепц бидний зорилго-д нийцэж байна, иймд та төслөө удирдаад, хэрэгжүүлнэ үү" гэсэн санал орж ирэх тохиолдлууд байдаг. Хөгжлийн банкны хувьд яг тийм санал орж ирж байсан. Хоёрдугаарт, Банк Санхүүгийн Академийн зээлийн эдийн засагч

нарт зориулсан анхны сургалтын программыг бий болгоход манай компани сонгон шалгарч энэхүү ажлыг USAID-н хөтөлбөрөөр хэрэгжүүлж байсан.

- Түүнчлэн Монголын санхүүгийн зах зээлийн хөгжилтэй холбоотой саналууд боловсруулж 2010 онд Засгийн Газраас санхүүгийн зах зээлийг эрчимжүүлэх ажлын хэсэгт оролцон ажилж Хөрөнгийн Биржийн ТУЗ-д болон Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-д гишүүнээр 2010-2011 онд ажиллаж ирсэн.

Ер нь бол салбарын хөгжлийг чухавчилж саналаа боловсруулан хүргүүлэх ажлыг Голомт Банкны Санхүүгийн Группын захирал хийж байхдаа үргэлжлүүлэн хийж ирсэн боловч харамсалтай нь өгч байгаа саналууд маань Засгийн газар солигдох, түүнээс хамааралтайгаар удирдлагууд солигдох тохиолдолд орхигдох хандлага байгаа нь санхүүгийн зах зээл хөгжихөд садаа болж байна. нгуут байхгүй болчихдог. Жишээлбэл, ТОСК-ийн зүгээс “Манайд түрээсийн орон сууцнууд байна. Түрээсээс тогтмол мөнгөн урсгал орж ирж байгаа. Иймд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаасууд гаргах боломж байгаа талаар судалж, хэрэгжүүлэх боломжийг судлахад олон хүндрэлтэй, хууль болон журмын авцалдаагүй байдал зэрэг ажиллах бололцоогүй зүйлүүд байсан.



ТЭР БҮГД ДЭЭР АЖИЛЛАЖ, ТУХАЙН ҮЕИЙН УДИРДЛАГУУДАД ЖУРАМ БОЛОН ХУУЛИУД ДЭЭР САНАЛ ХҮРГҮҮЛЖ БАЙСАН ХЭДИЙ Ч СОНГУУЛЬ БОЛЖ, ДАРААГИЙН УДИРДЛАГУУД НЬ ӨМНӨХ ХИЙСЭН АЖЛУУДЫГ “МЭДЭХГҮЙ, ТАНИХГҮЙ” Л БОЛООД ЯВЧИХСАН. БИДНИЙ ХУВЬД БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА УЧРААС ТЭР БОЛГОНЫ АРААС ХӨӨЦӨЛДӨӨД ЯВАХ БОЛОЛЦОО БАЙХГҮЙ.



Уг нь Монгол улс аливаа нэг хөгжлийн шийдлийн гарцаа концепцийн хувьд баталсан бол тэр концепцээ дор хаяж 10 жил тогтвортой хэрэгжүүлэх ёстой. Тэгэж байж тэр концепц үр дүн гарах ёстой. Гэтэл засаг солигдоход дагаад өөрчлөгдөөд анхны гаргасан гаргалгаа өөрчлөгдөж байгаа нь хөгжлийн гарц бус гацаа болж байна.

Жишээлвэл Хөгжлийн банк нь улс орны томоохон бүтээн байгуулалт болон арилжааны банкууд хийж гүцэтгэх боломжгүй төслүүдийг дэмжих хэрэгцээтэй байтал 888 гэх мэт төслүүдийг хэрэгжүүлж харилцагч тэр, банк ч тэр асуудалд орж байгаа нь харамсалтай байна.



Хөгжлийн банкны хувьд таны анх батлуулж байсан концепцоос их өөрчлөгдсөн байх. Тэгэхээр төрийн стратегийн шинжтэй томоохон бүтцийн концепцыг байнга өөрчлөхгүй байхын тулд хуулиар маш сайн хамгаалж өгөх ёстой болов уу. Хөгжлийн банкны тухай хуулинд энэ чиглэлийн зохицуулалтууд хэр тусгагдаж өгсөн бэ?

Бид анх байгуулагдахдаа цаасан дээр л байгуулагдсан учраас хуулиа байнга уншиж, бүх зүйлийг хуулинд нийцүүлж хийдэг байсан. Анх намайг томилогдож байхад Хөдөө аж ахуйн яамнаас “Жижиг, дунд үйлдвэрлэлүүдээ дэмжүүлмээр байна” гээд хүсэлт ирүүлдэг байсан. Манайх бодлогын банк учир Их хурлаас баталсан томоохон төслүүдээ санхүүжүүлэх чиг үүрэгтэй гэсэн бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Гэхдээ нэг жилийн дараа Их хурлаас Жижиг, дунд үйлдвэрлэлийн санд нь хөрөнгө гаргах шаардлагатай гэсэн тогтоолуудын дагуу 60 тэрбум төгрөгийг зөвхөн арилжааны банкуудар дамжуулахаар зохицуулалттай санхүүжилт хийж байлаа. Улс төрийн нөлөөллөөр олгогддог Сангийн шууд зээлүүдийг тэр үед олгох боломжгүй байдлаар шийдэл гаргаж байсан. Түүнчлэн Хөгжлийн банк анх байгуулагдаж байх үед Их хурал болон Засгийн газрын тогтоолуудаар дийлэнхи санхүүжилт маань замын төслүүдэд зориулагдаж байсан. Зам өөрөө эргэж ашиг олохгүй учраас тухайн үед зээл эргэн төлөгдөх эрсдэлийг хаахын тулд Сангийн яам, ЗТЯ-тай гурвалсан гэрээ байгуулж байсан.

Ингэснээр Сангийн яам тухайн жилийнхээ төсвөөр дамжуулж, зээлийн эргэн төлөлтийг хариуцах гэх зэргээр эрсдэлийг хянах механизмууд маш тодорхой байсан нь одоо алдагдчихаад байна. Хоёрдугаарт, зөвхөн УИХ-аар баталсан төсөлд л санхүүжилт хийдэг байсан. Тэр утгаараа гадаадын хөрөнгө оруулагчууд болон түншүүд Хөгжлийн банктай хамтрахад эрх зүйн орчин, статус нь маш

тодорхой байсан. Одоо бол нэг тийм, хоёрдмол л болчихоод байгаа юм. Бид ганц нэг сонгуулиар Монгол Улсынхаа хөгжлийг хармааргүй байна. Монгол Улсыг хөгжүүлэх нь бидний ирээдүй, үр хүүхдэд маань хэрэгтэй. Ийм нэгдсэн нэг Монгол гэсэн ойлголт хүн болгонд байгаасай л гэж хүсч байна. Яагаад үүнийг хэлээд байна вэ гэхээр одоо сонгууль болох гэж байна. Сонгууль болдгоороо л болно, Монгол Улс цаашид хөгжих ёстой. Монгол улсын хөгжлийн бодлогууд ядаж хоёр Засгийн газрыг дамнаад, бодлогын үр дүнгээ үзэж бататгамаар байна.

Үр дүнд хүрсэн байна гэж үзвэл дараагийн чиглэлээ гаргаж болно шүү дээ. Дөнгөж төрөөд, эхнийхээ алхмуудыг хийж байхад л концепцоо өөрчилчихдөг болохоор үр дүнгийн үнэлгээ хийх ямар ч боломжгүй байгаад байна. Хөгжлийн банкны анхны концепцыг зөв хэрэгжүүлсэн бол Монгол Улсын хувьд гадагшаа гарах маш том цонх болох байсан юм. Төрийн оролцоотой бодлогын банк учраас гаднаас их хэмжээний хөрөнгийг хөнгөлөлтэй нөхцөлөөр татах боломжууд нэмэгдэх байсан.



Эдийн засагт мөнгөний эргэлтийг тасралтгүй байлгахын тулд бизнесийн орчин зохицуулалттай байх ёстой юм шиг санагддаг. Манайд төдийлөн зохицуулалтгүй байхаар ихэвчлэн импортын л бизнеснүүд цэцэглээд байх шиг. Нөгөөтэйгүүр төр нэг салбарыг хэт дэмжээд эхлэхээр бүгдээрээ тийшээ хошуурдаг, эргээд нийт салбарынхаа хөгжлийг хойш татдаг жишиг байгаад байна. Үүн дээр ямар зохицуулалт байж болох вэ?

Энэ дахиад л төрийн бодлоготой хамаатай асуудал. Тэргүүлэх чиглэлээ гаргаад ирээч гэхээр тийм зүйл гарч ирдэггүй. Тэргүүлэх чиглэлгүй болохоор бүх салбар ач холбогдолын хувьд ижил юм шиг харагддаг. Гэтэл Монгол Улсын хувьд тийм биш. Бид жишээ нь хүнсний салбараа тэргүүлэх чиглэл болгоод хөгжүүлэе.

Тэрний дараа хөнгөн үйлдвэр гэх мэт хөгжүүлэх хэрэгтэй байна. Бид бүгд л импортын хувцас, гутал хэрэглэж байгаа. Тэгвэл бор зүрхээрээ явж байгаа оёдлын, гутлын, хүнсний үйлдвэрүүдээ төр бодлогоороо дэмжих ёстой.



ИЙМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙ ЧИГЛЭЛ, ДЭС ДАРААЛАЛ БАЙХГҮЙ БОЛОХООР ТАНЫ ХЭЛСЭНЧЛЭН ГЭВ ГЭНЭТ МАШ ОЛОН ХҮН, МАШ ОЛОН АДИЛХАН КОМПАНИЙГ БАЙГУУЛДАГ. ТИЙМ НӨХЦӨЛ БАЙДАЛ РУУ ТӨР ӨӨРӨӨ ТҮЛХЭЭД БАЙГАА ЮМ.



Жишээ нь 888 төсөл. Яаж 10 шинэ гурилын үйлдвэр гэнэт бий болов, тэр нь өөрсдөд нь жижиг зах зээл дээр өрсөлдөх боломжгүй тул одоо муу зээл болох, зээлийн бүтцийг өөрчлөх, зах зээлийн өрсөлдөөнийг гажуудуулах зэрэг сөрөг үр нөлөөтэй болов. Зарим нэг шинэ үйлдвэр нь одоо хүртэл үүдээ нээгээгүй байх жишээний. Тэгэхээр зах зээлийн үйл ажиллагаанд нь төр байнга орж ирж нөлөөлж байгаа нь идний хөгжлийг хойш нь татаж байна. Энэ нөлөө нь ЖДҮС, Орон нутгийн хөгжлийн сан гэх зэрэг маш оновчгүй бүтцээр орж ирээд байгаа юм. Орон нутгаар явахаар жишээ нь ажилгаагүй цонхны үйлдвэр зөндөө байна.

Тэнд ямар ч тооцоолол байгаагүй л гэсэн үг. Энэ процесс хэр их өөрчлөдсөн бэ? Дээрээс нь “шууд олголт” гэж нэг айхтар зүйлийг гаргаад ирчихсэн нь ЖДҮ-н хөрөнгийг нөлөө бүхий хүмүүс завших, эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг бий болгож байгаа нь харамсалтай. Тэгээд тэр нь жилийн ердөө 3 хувийн хүүтэй буюу улсын төсөв болон татвар төлөгчдийн төлсөн татварын татаастай явж байна гэсэн үг.

Татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Улс орон манай эдийн засгийн бүтцэт эерэг нөлөө үзүүлэх инновацийг дэмжсэн салбаруудыг хөгжүүлэх тусгай зориулалтаар бага хүүтэй зээл олгож дэмжих бодлого олон улсад сайн хэрэгжиж байгаа жишгүүдийг манай улс хэрэгжүүлж болно. Гэхдээ энэ нь эдийн засгийн бүтцийг солонгоруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх шаардлагатай байна.



Энэ он гарсаар “Ковид-19” цар тахал дэлхий дахиныг хамарч, улс орнууд янз бүрийн бодлогын шийдвэр гаргаж байна. Манай улсын хувьд ч бас цаг үеийн шинжтэй, богино

хугацаанд хэрэгжих бодлого, шийдвэрүүдийг гаргаж байна. Та энэ цаг үед төр засгаас гаргаж байгаа шийдвэрүүдийг хэрхэн дүгнэж харж байна вэ?

Засгийн газраас гаргаж байгаа шийдвэрүүд их болгоомжтой, дийлэнхи тохиолдолд нийгмийн даатгал болон орлогын татвар төлөх хэмжээний компаниудад хандсан дэмжлэгүүд байна. Гэтэл манай улсын дийлэнхи компаниуд нь бичил, нийгмийн даатгалаа төлөх боломжгүй нь олон байна. Засгийн газар анх энэ бодлогоо гаргахдаа хямралын анхны төсөөлөл буюу “V” загвараар төлөвлөсөн байх. Одоо нөхцөл байдал нийлээдгүй хүндэрч хямралын хугацаа уртсах магадлал өндөр байна. Яг одоогоор яригдаж байгаа арга хэмжээнүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл бага. Харин эсрэгээрээ эдийн засгаа хэрэглээ талаас нь дэмжих арга хэмжээнүүд авах хэрэгтэй.

Эдийн засгаа дэмжих гэхээр том төслүүдээ яриад байгаа. Усан оргилуур, агаарын дүүжин тээвэр барина гэх ч юм уу. Тэр төслүүд нь хэдэн хүнийг ажилтай болгоод байна вэ гэхээр “100 хүн ч гэсэн Монголын л ард түмэн” гээд байгаа юм. Гэтэл Засгийн газрын шийдвэрүүд нь далаацтай, зөвхөн барилгын салбар, ноолуурын салбарыг дэмжсэн байж болохгүй. Монгол Улсын 3 сая хүнд хүрэх бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ бас зүгээр мөнгө тараамааргүй байна. Жишээ нь яг энэ үед нь бага хүүтэй зээлээ олгож болно шүү дээ.

Зүгээр нэг тараах биш. Үнэхээр үйл ажиллагаа тогтвортой явуулж, ажлын байраа хадгалж үлдсэн бол тэр ААН дэмжээд зээл өгөх, бусад татварыг нь бууруулах гэх мэт олон хөшүүргүүдийг судлаж үзэх шаардлагатай гэж харагдаж байна. Хямралын үед дэлхийн улс орнууд өөрийн эдийн засгаа тэтгэхэд хувийн болон улсын хөрөнгө оруулагч нар оролцдог. Тэгэхлээр, Дэлхийн банк, АХБ гэх мэт донорын байгууллагуудаас өөр санхүүжилтүүд орж ирэх магадлал бага байна.



Мөнгөний бодлогын хувьд ихэнх улс орнууд бодлогын хүүгээ буурууллаа. Манай улс ч бас бодлогын хүүгээ хоёр удаа бууруулаад байна. Төв банкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг хэрхэн дүгнэж байна вэ?

Хөрөнгө оруулалт буурсан хямралын нөхцөлд мөнгөний нийлүүлэлтийг тэтгэх замаар эдийн засгаа дэмжих бодлогыг улс орнууд хэрэгжүүлдэг. Бусад улс орнууд ч ийм бодлогыг хэрэгжүүлж байгаа. Зээлийн хүүг бууруулахад Монголбанкны бодлого маш том нөлөө үзүүлж байгаа.

Түүгээр дамжаад арилжааны банкууд хүүгээ бууруулах нөхцөл нь бүрдэж байгаа учраас төв банкны бодлого зөв явж байгаа. Дунд нь янз бүрийн зээлийн буцаан төлөлтөө хойшлуулах гэх мэт арга хэмжээнүүд гарч иргэд, ААН болон банкуудын хооронд үл ойлгогдох байдлыг бий болгосон. Одоо журмууд нь даган гарч байгаа болов уу гэж найдаж байна. Гэхдээ энэ нь нэг их нэмэр болох арга хэмжээ бол биш. Энэ зээлийг төлөх нь тодорхой тул хойшлуулах нь компаниудын хувьд түр зуурын арга хэмжээ бөгөөд эрсдэл хэвээр л үлдэж байна.

Ярилцсанд баярлалаа.

АБАГА ХААНЫ АЛТАН ЗООС



1265-1282 ОН ТАБРИЗ ХОТ
ЖИН: 4.3 ГР, ГОЛЧ: 2.3 СМ 1265-1282

НҮҮР ТАЛ: "ХААНЫ НЭРЭЭР АБАГА ДЭЛДҮҮЛСЭН АРИГУ
АЛТАН" гэж монгол бичгээр бичсэн.

АР ТАЛ: "АЛЛАХААС ӨӨР БУРХАН ҮГҮЙ. МУХАММЕД БОЛ
АЛЛАХЫН ЭЛЧ" гэж араб бичигтэй.

“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ТАРХАЛТЫН СЦЕНАРИО ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ¹


Шинэ коронавируст /Ковид-19/ цар тахал нь тухайн улсын хүн амын бүтэц, эрүүл мэндийн салбарын чадавх, төрөөс хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ зэрэг олон хүчин зүйлсээс хамааран улс орнуудад харилцан адилгүй тархаж байна. Монгол Улсын хувьд 1 дүгээр сарын сүүл үеэс эхлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсний үр дүнд дотоодод тархалт гараагүй, нэгээс бусад тохиолдол нь зөөвөрлөгдөж орж ирсэн буюу нийт тохиолдлын тоо бага байна. Гэвч энэхүү вирусын халдвар манай хөрш зэргэлдээ орнууд болон дэлхийн ихэнх хэсэгт эрчимтэй тархаж байгаа өнөө үед эрсдэлийн түвшин өндөр хэвээр байна.

Иймээс Монгол Улсад коронавируст халдвар дотроос илэрч, тархах тохиолдолд бий болох нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлох нь холбогдох бэлтгэлийг хангахад ач холбогдолтой. Үүний тулд манай улстай нийгэм, эдийн засаг, хүн амын бүтцийн хувьд төстэй орнуудыг сонгон авч, тэдгээр улсын Ковид-19 цар тахлын тархалт, хамрах хүрээ нь ойролцоо байна гэсэн ялгаатай сценарио бүрийн хувьд Монголд хэрхэн тархах эрсдэлтэйг тодорхойлохыг зорилоо.

1. ОНОЛЫН ЗАГВАР

Kermack & McKendrick [1] нарын 1927 онд боловсруулсан SIR загвар нь халдварт өвчний тархалтын таамаглалыг боловсруулах үндсэн загвар юм. SIR загварт хүн амыг 3 бүлэгт хуваан авч үздэг ба эдгээр гурван бүлгүүдийн хоорондын холбоо хамаарлыг илэрхийлдэг.

- Susceptible буюу өртөмтгий бүлэг²
- Infectious буюу халдвар тээгч бүлэг³
- Recovered буюу халдварт өвчнөөс эдгэсэн бүлэг⁴
- $S + I + R = \text{Хүн ам}$



Бүлгүүдийн хооронд үргэлж шилжилт явагдаж байх бөгөөд үүнийг шилжилтийн хувь (transition

¹ Монголбанкны Ерөнхий Эдийн Засагч Д.Ган-Очир, ССГ-ын СуХ-ийн захирал Л.Даваажаргал, эдийн засагч Г.Мөнхбаяр, О.Цолмон, Э.Элбэгжаргал

² Өртөмтгий бүлэгт урьд нь халдвар авч байгаагүй, халдварт өвчний эсрэг дархлаагүй иргэд багтана.

³ Халдвар тээгч бүлэгт халдварт өвчин туссан бөгөөд өртөмтгий бүлэгтэй идэвхтэй харьцаж байгаа иргэд багтана.

⁴ Халдварт өвчнөөс эдгэсэн хүмүүсийн бүлэгт халдварт өвчин туссаад эдгэсэн, төрөлхийн халдварт өвчний эсрэг дархлаатай, бусдад халдвар халдаахааргүйгээр тусгаарлагдсан болон халдварт өвчний улмаар нас барсан хүмүүс багтана.

rate)-аар илэрхийлнэ. Тухайлбал **S** буюу халдварт өвчинд өртөмтгий бүлэг хүмүүсийн тодорхой хэсэг (**βSI**) нь халдвар авч **I** буюу халдвар тээгч бүлэгт, халдвар тээгч хүмүүсийн тодорхой хэсэг (**γI**) нь эдгэрч **R** буюу эдгэсэн бүлэгт нэмэгдэнэ.

β Нэг хүнтэй харьцах хүмүүсийн дундаж тоо болон өртөмтгий бүлгийн хүн халдвар тээгч бүлгийн хүнтэй харьцахад халдвар тархах магадлалын үржвэр.

γ Халдвар тээгч бүлгээс эдгэрсэн (үүнд тусгаарлагдсан, нас барсан, эдгэрсэн бүх тохиолдол хамаарна) хүмүүсийн хувь.

Энэхүү загварын тусламжтайгаар дараах мэдээллийг гарган авах боломжтой:

- Тархалтын оргил үе: Тархалтын оргил үе хэзээ болох, оргил үеийн нийт халдвар авсан хүмүүсийн тоо, нийт эдгэрсэн хүмүүсийн тоо
- Тархалт зогсох үе: Халдварт өвчний тархах нийт хугацаа, нийт халдвар авах хүний тоо, нийт эдгэрэх хүний тоо

2. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ

Ковид-19 цар тахлын онцлог, тархалтын хурд, цар хүрээ, нас баралтын түвшин нь улс орон бүрт харилцан адилгүй, тодорхойгүй байдал

өндөр байгаагаас шалтгаалан тархалтын үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ зэргийг нарийн тооцоолох боломж хомс байна. Гэхдээ өөрсдийн боломжит тоон мэдээлэл, загвар, арга аргачлалд үндэслэн коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын цар хүрээ, үргэлжлэх хугацаа зэргийг таамаглаж, тодорхойлох нь чухал хэвээр байна. Эдгээр үзүүлэлтийг SIR загвар ашиглан MATLAB програмын нэмэлт функцаар ялгаатай сценарио тус бүрийн хувьд тооцлоо.

2.1. SIR загварын тооцоо

MATLAB програмын нэмэлт fitVirusCOVID19 функц [2] нь SIR загварт үндэслэн Ковид-19 цар тахлын нийт тархалт болон үргэлжлэх хугацааг дараах үндсэн урьдач нөхцөлийн хүрээнд тооцдог.

fitVirusCOVID19 функцын үндсэн урьдач нөхцөл:

- Халдвар нь нэг үе шаттай тархана;
- Хүн амын тоо тогтмол;
- Хүмүүс газар нутагт жигд тархсан;
- Халдвар авсан хүмүүсийн эмчлэгдэх магадлал адилхан.


Түүнчлэн энэхүү загварын тооцоо нь бүртгэгдсэн халдварын тоон өгөгдөл дээр суурилдаг тул тархалтын таамаглал нь бодит тоон мэдээллийн чанараас ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл, тоон мэдээлэл шинэчлэгдэхэд, зэрэг параметруудийн үнэлгээ өөрчилөгдөх тул өвчний тархалтын төсөөлөл мөн өөрчлөгдөнө. Харин загварын параметрууд нь загвараар үнэлэгдсэн өвчлөлийн тоон утга болон бодит утгын хоорондох зөрүү буюу үлдэгдлийн квадратуудын нийлбэр утга хамгийн бага байхаар үнэлэгддэг.

Уг загварыг ашиглан бусад орнуудын Ковид-19 цар тахлын тархалтыг тооцдог бөгөөд Хятадын хувьд хийсэн тооцооллоос харахад SIR болон Логистик загварын үр дүн бодит байдлыг сайтар таамагласан байна [3]. Мөн энэхүү судалгаанд тус загварын таамаглал нийцтэй байдлыг шалгах зорилгоор тархалтын бодит хугацааг өөрчлөн тархалтын нийт хэмжээг тооцжээ. Үнэлгээний үр дүнгээс харахад 30 орчим өдрийн тоон өгөгдөлд үндэслэн тооцсон нийт халдварын тоо 110,000-120,000 хооронд байжээ. Харин халдварласан өдрийн бодит тоо нэмэгдэх тусам нийт тархалтын таамаглал багассаар 85,000 тохиолдол орчимд тогтворжсон байна. Энэ нь одоогийн Хятадын


нийт тархалтын тоотой маш ойролцоо, нийцтэй юм.

Зураг 2. Хятад улсын шинэ коронавирусын тархалтын үнэлгээний үр дүн

Коронавирусын тархалт



Коронавирусын тархалтын нийт хэмжээний тооцоолол



Эх сурвалж:Batista (2020)

SIR загварын үндсэн таамаглал болон Хятад улсын хувьд тооцсон үнэлгээний үр дүнгээс харахад бодит тоон өгөгдлийн хэмжээ урт байх, вирус тархалтыг намжаах хориг арга хэмжээнүүдийг өвчлөлийн өдрийн давтамжтай сайтар хэрэгжүүлж буй улс орнуудын хувьд энэхүү загварын тооцоо, үр дүн илүү бодитой, нийцтэй гарахаар байна.


2.2. Ковид-19 тархалтын сценарио шинжилгээ

Манай улсын хувьд урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайн хэрэгжүүлсний үр дүнд корона вирус тархалт дотоодод гараагүй, зөвөөрлөгдөж орж ирсэн тоо харьцангуй цөөн байгаа тул Монгол Улсын бодит тоон мэдээлэлд

үндэслэн нийт халдварын тоог SIR загвараар тооцоолох нь учир дутагдалтай юм.

Иймд Монгол Улстай нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн салбарын чадавх болон хүн амын бүтцийн хувьд төстэй орнуудыг сонгон авч, тэдгээр улсын Ковид-19 цар тахлын тархалт, хамрах хүрээнд суурилан сценарио шинжилгээг хийв. Энэ шинжилгээгээр манай улсад хэрхэн тархах эрсдэл байгааг тодорхойлох нь чухал мэдээлэл өгөхөөр байна. Энэ хүрээнд Бүгд Найрамдах Молдав Улс (Молдав улс), Бүгд Найрамдах Парагвай Улс (Парагвай улс) болон Босни ба Херцеговина Улс (Босни улс) нь Монгол Улстай ойролцоо, гэхдээ Ковид-19 цар тахлын тархалтын хувьд бага, дунд, өндөр тархацтай гэсэн сценарио болохоор байна.

Зураг 3. Ковид-19 цар тахлын тархалт, 2020.03.06 - 2020.04.19




Тайлбар: Халдвар бүртгэгдсэн өдрөөс эхлэн хугацаан цувааг үүсгэсэн.

Эх сурвалж: www.ourworldindata.org [4]

• Сценарио 1. Ковид-19 тархалтын түвшин бага: Бүгд Найрамдах Парагвай Улс

Парагвай улсын нийт хүн амын тоо 6.7 сая, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 5.4 мянган ам.доллар бөгөөд хүмүүн капиталын индекс 0.53 байгаа зэрэг нь манай улстай төстэй байна. Тус улсад коронавирусын анхны тохиолдол 3 дугаар сарын 7-ны өдөр илэрсэн бөгөөд 4 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 206 тохиолдол бүртгэгдээд байгаа нь манай улстай ойролцоо улсуудтай харьцуулахад бага түвшний үзүүлэлт юм. SIR загвараар Парагвай улсын нийт тархалтыг тооцоолоход 6 дугаар сарын эхэн үеэс тархалт намжиж, нийтдээ 450 орчим хүн коронавирусаар халдварлахаар байна.

Зураг 4. Ковид-19 цар тахлын тархалтын таамаглал, Парагвай Улс




Энд: - буюу үндсэн тархах тоо; - буюу дундаж тархах хугацаа; - буюу дундаж эдгэрэх хугацаа; - нийт өртөмтгийн бүлгийн тоо; - нийт халдварлах хүний тоо; - халдвар аваагүй хүний тоо; - Квадрат дундаж алдаа; Улаан хэсэг - Эрчимтэй тархалтын үе; Шар хэсэг - Тархалт тогтворжих үе; Ногоон хэсэг - Тархалт дуусах үе;

• Сценарио 2. Ковид-19 тархалтын түвшин дунд: Босни ба Херцеговина Улс

Босни улсын хүн ам, нийгэм, эрүүл мэндийн салбарын үзүүлэлтүүд нь Монгол улстай ихээхэн төстэй байна. Тухайлбал, тус улс нь нийт 3.3 сая хүн амтай, 1 км.кв-д ногдох хүний тоо 65 байгаа бөгөөд хүмүүн капиталын индекс нь манай улсынхтай ижил юм. Босни улсад коронавирусын анхны тохиолдол 3 дугаар сарын 5-ны өдөр илэрсэн бөгөөд үүнээс хойш 1 сарын хугацаанд 1285 тохиолдол бүртгэгдээд байгаа нь бусад төстэй улсуудтай харьцуулахад дунд түвшний үзүүлэлт юм. Тус улсын тархалтын түвшнийг SIR загварыг ашиглан таамаглаж үзэхэд 5 дугаар сарын эхэн хүртэл тархалт үргэлжилж, нийтдээ 1700 орчим хүн коронавирусаар халдварлахаар байна.

Зураг 5. Ковид-19 цар тахлын тархалтын таамаглал, Босни Улс



Энд: - буюу үндсэн тархах тоо; - буюу дундаж тархах хугацаа; - буюу дундаж эдгэрэх хугацаа; - нийт өртөмтгийн бүлгийн тоо; - нийт халдварлах хүний тоо; - халдвар аваагүй хүний тоо; - Квадрат


дундаж алдаа; Улаан хэсэг - Эрчимтэй тархалтын үе; Шар хэсэг - Тархалт тогтворжих үе; Ногоон хэсэг - Тархалт дуусах үе;

• **Сценарио 3. Ковид-19 тархалтын түвшин өндөр: Бүгд Найрамдах Молдав Улс**

Молдав улс нь нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, хүмүүн капиталын индекс, нягтрал зэрэг үзүүлэлтүүдээр манай улсаас харьцангуй доогуур түвшинд байгаа боловч нийт хүн амын тоо, 1000 хүнд ногдох эмнэлгийн ор болон сувилагчийн хүртээмж зэрэг үзүүлэлтүүдээр ихээхэн төстэй.

Молдав улсад коронавирусын анхны тохиолдол 3 дугаар сарын 7-ны өдөр илэрсэн бөгөөд 4 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 2472 тохиолдол бүртгэгдээд байгаа нь манай улстай ойролцоо улсуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. SIR загвараар тус улсын нийт тархалтыг тооцоолоход 5 дугаар сарын дунд үеэс тархалт намжиж, нийтдээ 3000 орчим хүн коронавирусаар халдварлах магадлалтай байна.

Зураг 6. Ковид-19 цар тахлын тархалтын таамаглал, Молдав Улс



Энд: - буюу үндсэн тархах тоо; - буюу дундаж тархах хугацаа; - буюу дундаж эдгэрэх хугацаа; - нийт өртөмтгийн бүлгийн тоо; - нийт халдварлах хүний тоо; - халдвар аваагүй хүний тоо; - Квадрат дундаж алдаа; Улаан хэсэг - Эрчимтэй тархалтын үе; Шар хэсэг - Тархалт тогтворжих үе; Ногоон хэсэг - Тархалт дуусах үе;

3. ДҮГНЭЛТ

Монгол Улс Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өндөр түвшинд авч хэрэгжүүлсэний үр дүнд дэлхий даяар тархаад буй цар тахлын халдвар манай улсад харьцангуй бага, зөвхөн зөөвөрлөгдөж ирсэн тохиолдлууд байна. Гэвч хөрш зэргэлдээ болон бусад улсад эрчимтэй тархаж буйтай зэрэгцэн манай улсын эрсдэлийн түвшин өндөр хэвээр байгаа тул хэрэв дотооддоо илрэх тохиолдолд үүсэж болзошгүй тархалтын эрсдэлийн цар хүрээг холбогдох загвар, аргачлалын дагуу судлан тодорхойлоо.

Халдварт өвчний дэгдэлт, тархалтын түвшинг урьдчилан тооцоолдог загваруудаас SIR загварыг ашиглан Монгол Улстай нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн салбарын чадавх, хүн амын бүтцийн хувьд төстэй орнуудыг сонгон авч, тэдгээр улсын Ковид-19 цар тахлын тархалт, хамрах хүрээ нь ялгаатай сценарио байхаар манай улсад хэрхэн тархах боломжтойг судаллаа.

Үнэлгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсын хувьд шинэ коронавируст /Ковид-19/ цар тахлын тархалт дунджаар 2-3 сар үргэлжлэх бөгөөд урьдчилан сэргийлэх хориг арга хэмжээг хэр хурдан, үр дүнтэй хэрэгжүүлэхээс хамаарч 450-3000 хүнд халдварлахаар байна. Монгол Улсын хэмжээнд эмнэлгийн 18,669 ор, амьсгалын 425 аппарат байгаа бөгөөд үүнээс 2,915 ор, тодорхой хэмжээний аппаратыг коронавирусын халдварын тохиолдлыг эмчлэх, хянаж ажиглах зориулалтаар бэлдсэн байна⁵. Бусад олон улсын судалгааны байгууллага, эрдэмтэд, судлаачдын хийсэн тооцоо шинжилгээнээс харахад Ковид-19 цар тахлын тархалт 5 дугаар сарын сүүл үеэр оргилдоо хүрч, 7 дугаар сарын эхээр намжих төлөвтэй байна. Иймд манай улсын хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээг 6-7 сар хүртэл үргэлжлүүлж, шаардлагатай бэлтгэлийг ханган, тандалт судалгаа сайн хийх зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх нь аюулт өвчний тархалтын цар хүрээг бууруулах үндсэн арга хэрэгсэл байхаар байна.

Ашигласан материал

- [1] W. O. Kermack ба McKendrick, "Contributions to the mathematical theory of epidemics," 1927.
- [2] M. Batista, "fitVirusCOVID19," MATLAB Central File Exchange, 10 April 2020. Available: <https://www.mathworks.com/matlabcentral/fileexchange/74658-fitviruscovid19>.
- [3] M. Batista, "Estimation of the final size of the coronavirus epidemic by the SIR model," 17 February 2020.
- [4] "www.ourworldindata.org,".
- [5] J. Graunt, *Natural and Political Observations made upon the Bills of Mortality*, 1662.
- [6] Imperial College COVID-19 Response Team, "The Global Impact of COVID-19 and Strategies for Mitigation and Suppression," 2020.
- [7] C. C. R. Group, "World-wide COVID-19 Outbreak Data Analysis and Prediction," 2020.
- [8] "www.worldometers.info,".

⁵ Эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын талаар хэвлэлийн бага хурал /2020.04.18-ны өдөр/

ДААТГАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ



Даатгал гэж юу вэ?

Хүн бүр амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө хамгаалахын тулд учирч болох эрсдэлээс сэргийлдэг хэдий ч "Гай газар дороос" гэдэг шиг аливаа өвчин зовлон, аюул осол хэлж ирдэггүй хийсэж ирдэг. Энэ үед хүн сэтгэл санааны, бие махбодийн, эд хөрөнгийн хохирол амсаж, түүнийг барагдуулах, даван туулахад тодорхой хэмжээний санхүүгийн дарамт үүсдэг. Иймээс аливаа хувь хүн, албан байгууллагын хэвийн байдлыг алдагдуулах, санамсаргүй, эрсдэл дагуулсан үйл явцаас үүсэх хохирлыг бууруулах, нөхөх санхүүгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол даатгал юм.

Хүмүүс хэсэг бүлгээрээ дундын сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах нь даатгалын үндсэн хэлбэр юм. Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг бөгөөд учирсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхүйц байх боломжтой. Үүнтэй адил даатгал бол бага зардал гарган их хэмжээний хохирлоос хамгаалагдах боломж буюу хариуцлага, хамгаалалт, амар тайван байдлыг эрэлхийлсэн эрсдэлийн удирдлагын энгийн шийдэл гэж ойлгож болно.

 Техникийн эрсдэл	 Ахуйн эрсдэл	 Байгалийн эрсдэл
 Араатан амьтны нөлөөгөөр үүсэх эрсдэл	 Бусдад хорлогдох эрсдэл	 Зам тээврийн осолд өртөх эрсдэл
 Архаг хууч өвчин	 Ердийн өвчин	 Гэнэтийн өвчин

Гэнэтийн эрсдэл хэнд ч, хэзээ ч тохиолдох магадлалтай тул түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд учирч болзошгүй хохирлыг бусдад шилжүүлэх буюу даатгалд хамрагдах боломж байдаг.

Эрсдэлийг даатгагдах болон даатгагдахгүй эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой **эрсдэлийг даатгагдах эрсдэл** гэдэг.

Даатгуулж болох эрсдэлийн төрлүүд

- ✓ Хувь хүний эрсдэл - Амь нас, эрүүл мэнд учирч болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: автомашины осолд өртөх, өвчин тусах г.м.
- ✓ Эд хөрөнгийн эрсдэл - Таны эд хөрөнгөд бүрэн буюу хэсэгчлэн хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: хулгайд юмаа алдах, орон гэр нь гал түймэрт өртөх г.м.
- ✓ Хариуцлагын эрсдэл - Аливаа хариуцлагагүй болон санаандгүй үйлдлээс болж бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: автомашин жолоодож байхдаа бусдыг гэмтээх, эд хөрөнгөд нь хохирол учруулах г.м.

Даатгалд хамрагддаггүй эрсдэлийн төрлүүд:

- ✓ Элэгдэл, хорогдол
- ✓ Техникийг шалган турших явцад гарсан хохирол
- ✓ Хувь сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл



Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдэлээ даатгуулж даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох итгэлцэл дээр суурилдаг үйл ажиллагаа юм. Иймд иргэн та даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцаа болон даатгалтай холбогдох дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.

Даатгалын харилцаанд оролцогчид, хууль эрх зүйн зохицуулалт

Даатгалын үйл ажиллагаа нь даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй харилцаа юм.



Энэхүү харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогчид, төрийн байгууллагууд оролцдог. Даатгалын тухай хуульд зааснаар даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам даатгалын бодлогыг, Санхүүгийн зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлдэг бол, “Даатгалын тухай хууль” болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”-ийн дагуу даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогчид буюу даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч нь Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг. Даатгуулагч нь даатгалын компанийн салбар нэгжид хандан даатгуулахаас гадна даатгалын төлөөлөгч, зуучлагчаар дамжуулан даатгалын гэрээ байгуулах боломжтой юм. Та даатгуулагчийн хувьд зөвлөгөө авахыг хүсвэл даатгалын компанийн ажилтан, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчид хандаж болно.

Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилж бөгөөд ангилал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтоодог бол сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно. Хувь хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр даатгуулах эсэх нь сонголттой бол сайн дурын даатгал, харин аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд заавал даатгуулахаар хуульчилсныг албан журмын даатгал гэнэ. Жишээлбэл, Иргэн А автомашин жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ санамсаргүй бусдын авто машиныг мөргөж гэмтээх тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын даатгалаар нөхөн төлүүлж болно. Харин тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан бол өөрийн авто машинд учирсан хохирлыг барагдуулж болох юм. Үүнээс машин барьж авто замын хөдөлгөөнд оролцдог л бол жолооч та жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах учиртай, харин тээврийн хэрэгслээ даатгуулах эсэх нь таны сонголт юм.


Хүснэгт 5. Даатгалын хэлбэр, тодорхойлолт

/Хуулиар болон СЗХ-оос тогтоосон нийт даатгалын хэлбэрээс дараах хэлбэрүүдийг сонгож тайлбарласан болно/

№	ДААТГАЛЫН ТӨРӨЛ	АГУУЛГА
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна
2	Автотээврийн хэрэгслийн даатгал	Автотээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй
3	Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
4	Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна
5	Жолоочийн хариуцлагын даатгал	Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахад даатгагчаас хохирогчид мөнгөн төлбөр төлөх, хохирогчийн эрхийг хамгаалах нөхцөл бүхий даатгал
6	Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна
7	Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал
8	Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч, эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна

Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд даатгалын бүтээгдэхүүн нь даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл, хүүхдийн гэнэтийн ослын даатгал, хашаа, байшингийн даатгал, гадаадад зорчигчийн даатгал, хүүхдийн боловсролын хуримтлалын даатгал г.м.

Даатгалын компаниудын санал болгодог олон төрлийн даатгалын бүтээгдэхүүнээс хэрхэн сонголт хийх талаарх зөвлөгөөг дараах зургаас харж болно.



4. Даатгалын тохиолдол гарах, нөхөн төлбөр авах

Хэрэв даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол гарсан бол хохирлыг нөхөх үүргийг даатгагч хүлээдэг.

“Даатгалын тухай хууль”, “Иргэний хууль” болон даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн эрх, үүргийг тодорхой заасан байдаг бөгөөд ялангуяа даатгуулагч өөрийн хүлээх үүргээ маш сайн мэддэг байх нь чухал юм.

Тухайлбал, даатгалын тохиолдол болсон үед тодорхой хугацааны дотор даатгагчдаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас нөхөн төлбөр авч чадахгүй нөхцөл үүсэх юм.





НЯГТЛАХ

ТУСАМ

АЮУЛГҮЙ!

**САНХҮҮГИЙН ЛУЙВРААС
СЭРГИЙЛЬЕ!**